

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ-135
АГААРЫН ТЭЭВРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА-
БАГТААМЖ БАГАТАЙ ОНГОЦ, НИСДЭГ ТЭРЭГ**

ИНД-135-д 2010.04.16–ны өдрөөс хойш хийгдсэн нэмэлт, өөрчлөлтүүд:

Нэмэлт, өөрчлөлт- 5 /ЗТБХБ-ын Сайдын 2011.04.22-ны 123 дугаар тушаал/

“А” Бүлэг-ò, 135.269 /Нислэгийн бичигч төхөөрөмжүүд /FDR,CVR/-ийн ажиллагаа болон бичлэгийг хадгалах/-р зүйл нэмсэн

Нэмэлт, өөрчлөлт- 6 /Зам тээврийн Сайдын 2013.01.11-ны 02 дугаар тушаал/

“К” Бүлэг-ò, 135.455 /Нисэх багийн гишүүдийн ур чадварыг шалгах/-ын (а)-гийн 5/-д “болон” гэснийг “эсхүл” гэж өөрчилсөн

| | |
|---|-----------|
| А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ | 5 |
| 135.1. Зорилго | 5 |
| 135.3. Тодорхойлолт, товчлол | 5 |
| 135.5. Заавар, журмыг дагаж мөрдөх..... | 6 |
| 135.7. Зорчигчдод аюулгүй ажиллагааны мэдээлэл өгөх | 6 |
| Б БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА | 6 |
| 135.51. Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар | 6 |
| 135.53. Багийн гишүүдийн нийтлэг хэл | 6 |
| 135.55. Нислэгийн өмнөх бэлтгэл ба нислэгийн төлөвлөлт | 6 |
| 135.57. Авран хамгаалах тоног төхөөрөмжийн тухай мэдээлэл | 7 |
| 135.59. Түлш | 7 |
| 135.61. Бүхээгийн шалгах хуудас | 8 |
| 135.63. Зорчигчид тавигдах аюулгүй ажиллагааны шаардлага | 8 |
| 135.65. Нисэх багийн бүхээгт нэвтрэх | 8 |
| 135.67. Нислэгийн бичлэгийн хэрэгсэлд тавигдах шаардлага | 8 |
| 135.69. Түлшээр сумлах, түлш юүлэх ажиллагаа | 9 |
| 135.71. Түлш асгарах | 9 |
| 135.73. Аэродромын ашиглалт | 9 |
| 135.75. Нэг хөдөлгүүртэй агаарын хөлгөөр ХНД /IFR/-ийн дагуу нислэг үйлдэх | 10 |
| 135.77. Үйл ажиллагааг хязгаарлах буюу түр зогсоох | 11 |
| 135.79. ИХНД /VFR/-ээр үйлдэх нислэгийн хамгийн бага өндөр..... | 11 |
| 135.81. Усан дээгүүрх нислэг | 12 |
| 135.83. Онцгой нөхцөл байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө | 12 |
| 135.85. Хүн ам шигүү суурьшсан газар нутаг дээгүүрх нислэг | 132 |
| 135.87. Нисдэг тэрэгний татлагат ачаалал | 13 |
| В БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯЗГААРЛАЛТ БОЛОН ЦАГ УУРЫН ШААРДЛАГУУД | 14 |
| 135.101. Цаг уурын мэдээ..... | 14 |
| 135.103. ИХНД-ээр нислэг үйлдэх цаг уурын нөхцөл | 143 |
| 135.105. ХНД-ээр нислэг үйлдэх цаг уурын нөхцөл | 15 |
| 135.107. Аэродромын минимум - ХНД-ээр үйлдэх нислэг | 15 |
| 135.109. ХНД-ээр хөөрөлт үйлдэх хязгаарлалтууд | 15 |
| 135.111. Багасгасан горимоор хөөрөлт үйлдэх минимум..... | 165 |
| 135.113. ХНД-ээр нислэг үйлдэх | 16 |
| Г БҮЛЭГ. НИСЛЭГ, ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ | 16 |
| 135.151. Зорилго..... | 16 |
| 135.153. Нислэг, техникийн үзүүлэлтийг мөрдөх | 17 |
| 135.155. Онгоцны ерөнхий үзүүлэлт | 17 |
| 135.157. Хөөрөлтийн зай | 17 |
| 135.159. ХБЗ-ны гадаргуу болон налуууг тооцоолох хүчин зүйлүүд | 187 |
| 135.161. Хөөрөлт, гаралтын бүдүүвч - ХНД-ээр нислэг үйлдэх онгоц | 18 |
| 135.163. Хөдөлгүүрийн татгалзал - градиент ба онгоцны уналтыг засах | 19 |
| 135.165. Чиг шулуун нислэгийн үед эрсдэлтэй хөдөлгүүр (critical engine) татгалзах | 19 |
| 135.167. Нислэгийн 90 минутын хязгаарлалт | 20 |

| | |
|---|------------|
| 135.169. Буултын өндөр авалт - нисэн очих болон нөөц аэродром | 21 |
| 135.171. Буултын зай - хуурай зурвас | 211 |
| 135.173. Буултын зай - нойтон ба бохирдсон зурвас..... | 22 |
| 135.175. Огцом ойртолт ба богино зайд буулт үйлдэх арга | 222 |
| 135.177. FAR Part 23 commuter category ба SFAR41 | 23 |
| 135.179. Хөөрөлтийн зай | 23 |
| 135.181. Хөөрөлтийн үеийн нислэгийн зурвас ба гаралт /SID/ | 243 |
| 135.183. Буултын зай - хуурай зурвас | 254 |
| 135.185. Буултын зай - нойтон ба бохирдсон зурвас | 255 |
| Д БҮЛЭГ. ЖИН БА ТӨВЛӨРӨЛТ | 255 |
| 135.201. Зорчигч, ачаа болон тээшний жин | 255 |
| 135.203. Агаарын хөлгийн ачааллын хязгаарлалтууд | 265 |
| Е БҮЛЭГ. ХЭРЭГЛЭЛ БОЛОН ТОНОГЛОЛ | 266 |
| 135.251. Ерөнхий зүйл | 266 |
| 135.253. Суудлын даруулга | 266 |
| 135.255. Нэмэлт хэрэглэлүүд | 276 |
| 135.257. Шөнийн нислэг | 276 |
| 135.259. Хэрэглэлийн нислэгийн дүрэм | 276 |
| 135.261. Аэран хамгаалах тоноглол | 277 |
| 135.263. Бүхээгийн дуу чимээ бичигч /CVR/..... | 277 |
| 135.265. Нислэгийн өгөгдөхүүн бичигч /FDR/..... | 287 |
| 135.267. Нэмэлт авиагоризонт | 287 |
| 135.269. Нислэгийн бичигч төхөөрөмжүүд /FDR, CVR/-ийн ажиллагаа болон бичлэгийг хадгалах..... | 27 |
| Ж БҮЛЭГ. ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭ | 288 |
| 135.301. Техник үйлчилгээ | 288 |
| 135.303. Агаарын хөлгийн НТЧ-ыг хариуцах | 288 |
| 135.305. Агаарын хөлгийн техник үйлчилгээний талаар хүлээх үүрэг | 298 |
| 135.307. Сургалтын болон мэдээллийн хөтөлбөр | 29 |
| 135.309. Техник үйлчилгээг баталгаажуулах ажилтанд тавигдах шаардлага | 29 |
| 135.311. ТҮ-нд хяналт тавих ажилтанд тавигдах шаардлага | 29 |
| 135.313. ТҮ-ний ажилтны ажлын цагийн хязгаарлалт | 29 |
| 135.315. Техник үйлчилгээг дүгнэх..... | 29 |
| З БҮЛЭГ. НИСЭХ БАГИЙН ГИШҮҮДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД..... | 310 |
| 135.351. Нисэх багийг томилох | 310 |
| 135.353. Агаарын хөлгийн даргын дадлага туршлагад тавигдах шаардлагууд..... | 310 |
| 135.355. Хамгийн цөөн нисэх баг- ХНД-ийн дагуу үйлдэх нислэг | 311 |
| И БҮЛЭГ. СУРГАЛТ ДАДЛАГА | 321 |
| 135.401. Ерөнхий зүйл | 321 |
| 135.403. Сургалт дадлагын бүртгэл тэмдэглэл | 322 |
| 135.405. Нисэх багийн гишүүдийн анхан шатны сургалт | 322 |
| 135.407. Нисэх багийн гишүүдийн шилжин сургалт | 332 |
| 135.409. Давтан сургалт | 332 |
| 135.411. Багийн бусад гишүүдийн сургалтын хөтөлбөр..... | 332 |
| 135.413. Багш нисгэгчийн мэргэшлийн бэлтгэлд тавигдах шаардлага | 333 |
| К БҮЛЭГ. БАГИЙН ГИШҮҮДИЙН УР ЧАДВАРТ ТАВИГДАХ ШААРДЛАГУУД ... | 343 |
| 135.451. Ерөнхий зүйл | 343 |

| | |
|--|------------|
| 135.453. Шалгах нисгэгчийн бэлтгэл, ур чадвар | 343 |
| 135.455. Нисэх багийн гишүүдийн ур чадварыг шалгах | 344 |
| 135.457. Шалгалт өгсөнд тооцох нөхцөл | 355 |
| 135.459. Шалгалтын бүртгэл тэмдэглэлийг хадгалах | 355 |
| Л БҮЛЭГ. НИСЭХ БАГИЙН ГИШҮҮДИЙН АЖИЛ, АМРАЛТЫН ЦАГИЙН ЗОХИЦУУЛАЛТ | 355 |
| 135.501. Гэрчилгээ эзэмшигчийн үүрэг хариуцлага | 355 |
| 135.503. Нисэх багийн гишүүний үүрэг хариуцлага | 366 |
| М БҮЛЭГ. ЗААВАР, НИСЛЭГИЙН ДЭВТЭР БОЛОН БҮРТГЭЛ | 376 |
| 135.551. Үйл ажиллагааны мэдээлэл | 376 |
| 135.553. Агаарын хөлгийн бүхээгт авч явах бичиг баримтууд | 376 |
| 135.555. Нислэгийн өдөр тутмын бүртгэл | 377 |
| 135.557. Бүртгэлийг хадгалах | 377 |
| ХАВСРАЛТ А. ХЭРЭГЛЭЛ, ТОНОГЛОЛЫН НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАДВАР БҮХИЙ БҮТЦИЙН СТАНДАРТ | 388 |
| А.1. Бүхээгийн дуу чимээ бичигч / Cockpit voice recorder/..... | 388 |
| А.2. Нислэгийн өгөгдөхүүн бичигч / Flight data recorder/..... | 38 |
| ХАВСРАЛТ Б. ХӨӨРӨХ, БУУХ ЗУРВАС (ХБЗ) | 39 |
| Б.1.1. ХБЗ-ны хамгийн бага өргөн | 39 |
| Б.1.2. Хүснэгт 2-ыг ашиглан ARC-ийг тодорхойлох | 39 |
| Б.1.3. Хүснэгт 2-ыг ашиглан ХБЗ-ны хамгийн бага өргөнийг тодорхойлох..... | 39 |
| Б.1.4. Нислэгийн талбайн хамгийн бага өргөн | 40 |

Зам, тээвэр, барилга хот байгуулалтын Сайдын
2010 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 111 дүгээр
тушаалын 10 дугаар хавсралт

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ-135
АГААРЫН ТЭЭВРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА-
БАГТААМЖ БАГАТАЙ ОНГОЦ, НИСДЭГ ТЭРЭГ**

А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

135.1. Зорилго

(а) Энэ дүрмээр дараах төрлийн агаарын хөлгөөр гүйцэтгэх агаарын тээврийн үйл ажиллагааг зохицуулна:

- 1/ 12 болон түүнээс цөөн зорчигчийн суудалтай онгоц;
- 2/ нисдэг тэрэг.

(б) Энэ зүйлийн (а)-гийн 1/-д заасан онгоц нэг хөдөлгүүртэй бол хөөрөлтийн хамгийн их жин нь 5700 кг-аас ихгүй байна.

(в) Энэ зүйлийн (а)-гийн 1/-д заасан онгоцоор зөвхөн ачаа тээвэрлэх бол ачааны нийт жин (brutto) нь 2000 кг-аас ихгүй байна.

135.3. Тодорхойлолт, товчлол

Босго гэж саадаас чөлөөтэй ойртолтын гадаргуу нь хөөрөлт буултын зурвас (цаашид ХБЗ гэх)-ны гадаргуутай 1:20 харьцаатай огтлолцож буй цэгийг;

Гэрчилгээ эзэмшигч гэж ИНД-119-ийн дагуу гэрчилгээжиж, агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх эрх олгогдсон аж ахуйн нэгж, байгууллагыг;

Нисдэг тэрэгний гадна ачаалал гэж олс, тор, татлаганы тусламжтайгаар хүн болон ачааг нисдэг тэрэгний гадна /доод/ талд бэхлэн тээвэрлэх, эсхүл татан авахыг;

Үйл ажиллагааны заавар гэж ИНД-119-д шаардсан, агаарын тээвэрлэгчийн нислэг, техникийн үйл ажиллагаанд мөрдөх үндсэн баримт бичгийг;

Хөөрөлт, гаралтын бүдүүвч, нислэгийн чиглэл, хөөрөлт үйлдэх зай, болон хөөрөлтийн гүйлт гэдгийг тухайн агаарын хөлгийг гэрчилгээжүүлсэн дүрэмд заасантай адил утгаар авч үзнэ.

- АIP- нисэхийн мэдээллийн эмхэтгэл
- ХБЗ- хөөрч буух зурвас
- ХНД- хэрэглэлийн нислэгийн дүрэм

ИХНД- ил харааны нислэгийн дүрэм
НТЧ- нислэгт тэнцэх чадвар
MEL - нислэгт зөвшөөрөгдөх хамгийн цөөн тоноглолын жагсаалт.

135.5. Заавар, журмыг дагаж мөрдөх

(а) Гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаанд оролцож байгаа нисэх багийн гишүүд болон инженер техникийн ажилтнууд нь иргэний нисэхийн хууль, дүрэм, гэрчилгээ эзэмшигчийн заавар, журмуудыг судалж, дагаж мөрдөх үүрэгтэй.

135.7. Зорчигчдод аюулгүй ажиллагааны мэдээлэл өгөх

(а) Агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд (агаарын хөлгийн дарга болон багийн гишүүн) нь зорчигч бүрд, тухайн нислэгийн онцлогт тохирсон ослын болон аюулгүй ажиллагааны талаарх дараах мэдээллийг танилцуулсан байна:

- 1/ хөөрөлт бүрийн өмнө суудлын даруулгыг өөртөө тохируулж хийх, бэхлэх талаар;
- 2/ тамхи татахыг хориглох талаар;
- 3/ багийн гишүүдээс өгч буй аюулгүй ажиллагааны заавар, мэдээллийг бүх зорчигч дагаж мөрдөх талаар;
- 4/ тухайн агаарын хөлөгт тохирсон ослын үеийн гарц, хаалга болон түүнийг ашиглах заавар, аргачлалыг харуулсан зураг болон мэдээллийн хуудас, шаардлагатай бусад танилцуулга.

Б БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

135.51. Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар

(а) Гэрчилгээ эзэмшигчийн агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа агаарын хөлөг бүр нь зохих ангиллын хүчин төгөлдөр НТЧ-ын гэрчилгээтэй байна.

135.53. Багийн гишүүдийн нийтлэг хэл

(а) Гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлсийг бататгасан байна:

- 1/ нисэх багийн гишүүд нийтлэг нэг хэлээр харилцан ойлголцох ба нисэх багийн аль нэг гишүүн нислэгийн хөдөлгөөний хэллэгээр ойлголцдог байх;
- 2/ нэг нисгэгч бүхий агаарын хөлгийн гишүүн монгол хэлээр зохих түвшинд харилцан ойлголцох боломжгүй тохиолдолд НХУ-ын мэргэжлийн операторыг оролцуулах;
- 3/ нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа нисэх бүрэлдэхүүн нь холбогдох дүрэм, журам, зааврыг уншиж, танилцан, ойлгож мөрдлөг болгох.

135.55. Нислэгийн өмнөх бэлтгэл ба нислэгийн төлөвлөлт

(а) Агаарын хөлгийн дарга нь нислэг бүрийн өмнө агаарын хөлгийн байдал, хэрэглэл тоноглолын ажиллагаа хэвийн, төвлөрөлт зөв эсэх, ачааллыг зохих байрлалд ачсан, нислэгийн тооцоо (компьютер) нислэг бүрт хийгдсэн байдлыг шалгана.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь төлөвлөсөн нислэгийн бэлтгэлийг хангахад шаардлагатай мэдээллийг агаарын хөлгийн даргад өгсөн байна.

(в) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн төлөвлөгөөг:

- 1/ агаарын тээврийн үйл ажиллагаа бүрийн өмнө;
- 2/ зорчигч, ачаа тээш тээвэрлэх арилжааны нислэг бүрийн өмнө бэлтгэнэ.

(г) Энэ зүйлийн (б)-д шаардсан нислэгийн төлөвлөгөөг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ (цаашид НХҮ гэх)-ний байгууллагад танилцуулна. Хэрэв нислэгийн үйл ажиллагаа нь хяналтгүй агаарын зайд, ИХНД-ээр үйлдэгдэх бол нислэгийн төлөвлөгөөг:

- 1/ нислэгийн хөдөлгөөний холбогдох салбар нэгжид;
- 2/ адил чанарын нислэгийн мэдээллийн үйлчилгээний нэгжид танилцуулна.

(д) ИНД-91-ийн заалтуудаас гадна, гэрчилгээ эзэмшигч нислэгийн төлөвлөгөөг НХҮ-ний байгууллагад танилцуулж, агаарын хөлгийн даргад төлөвлөгөөний дагуу зөвлөмж өгсөн бол агаарын хөлгийн дарга нислэгийн төлөвлөгөөг батлах шаардлагагүй.

135.57. Авран хамгаалах тоног төхөөрөмжийн тухай мэдээлэл

(а) Гэрчилгээ эзэмшигч нь Эрэн хайх, авран туслах мэдээлэл зохицуулах төвтэй шуурхай холбоо барихад зориулсан мэдээллийг агаарын хөлөгт байгаа авран хамгаалах тоног төхөөрөмжүүд дээр байрлуулсан байна.

(б) Далайн эргээс 18 км /10 nm/-ээс дээш зайд үйлдэх нислэгийн үед, энэ зүйлийн (а)-д шаардсан мэдээлэлд дараах зүйлүүд багтсан байна:

- 1/ аврах завины тоо ширхэг, өнгө, төрөл маяг;
- 2/ дохионы пуужин байгаа эсэх;
- 3/ эмнэлгийн яаралтай тусламжийн болон цэвэр усны хангамжийн талаарх нарийвчилсан мэдээлэл;
- 4/ онцгой нөхцөл байдлын үед ашиглах зөөврийн радио төхөөрөмжийн төрөл, маяг, ажиллах давтамж.

135.59. Түлш

(а) Гэрчилгээ эзэмшигч нь төлөвлөсөн нислэг, нислэгийн явц дахь дахин төлөвлөлтөд нийцсэн Түлшний заавартай байна.

(б) Түлшийг тооцоолохдоо дараах зүйлүүдийг үндэслэнэ:

- 1/ үйлдвэрлэгчийн зааварт тусгагдсан, эсхүл тэдгээрийг ашиглан боловсруулсан, агаарын хөлгийн маягийн гэрчилгээнд бичигдсэн өгөгдөхүүнүүдэд тохирсон журам, хүснэгт, график;
- 2/ төлөвлөсөн нислэгийн нөхцөл.

(в) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгт шаардлагатай түлшийг тооцоолохдоо дараах хүчин зүйлийг харгалзана:

- 1/ явгалалтын үед зарцуулагдах түлш;
- 2/ аялалд зарцуулагдах түлш;
- 3/ нөөц түлш:
 - 3.1 гэнэтийн үед ашиглах түлш;

3.2 нөөц аэродром руу нисэхэд шаардагдах түлш /эхний буудалд нисэн очсоноос хойш 30 минутаас доошгүй хугацаанд нисэх хэмжээний түлштэй байх/;

3.3 нислэгийн төрлөөс шалтгаалан, нэмэгдэл түлш.

4/ хэрэв шаардлагатай бол, нислэгийн явц дахь дахин төлөвлөлтөд шаардагдах түлш.

(г) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн төлөвлөгөө, эсхүл нислэгийн явц дахь дахин төлөвлөлтийг хийхдээ энэ зүйлийн (а)-д заасан Түлшний зааврыг дагаж мөрдөнө.

135.61. Бүхээгийн шалгах хуудас

(а) Нисэх багийн гишүүд нь ердийн болон онцгой тохиолдлын үед тухайн агаарын хөлгийн Нислэгийн ашиглалтын зааварт нийцсэн бүхээгийн шалгах хуудсыг ашиглана.

135.63. Зорчигчид тавигдах аюулгүй ажиллагааны шаардлага

(а) Агаарын хөлгийн дарга нь:

- 1/ согтууруулах ундаа, мансууруулах бодис, эм тариа хэрэглэсний улмаас агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа болон зорчигчдод аюул учруулж болзошгүй аливаа этгээдийг тээвэрлэхээс татгалзана;
- 2/ өвчтэй болон гэмтэл бэртэлтэй зорчигчийг, ослын үед тусламж үзүүлэхэд тохиромжтой суудалд суулгана;
- 3/ хууль, хяналтын байгууллагын ажилтны харгалзаж яваа зорчигчийг гэрчилгээ эзэмшигчийн холбогдох зааварт заасан журмын дагуу тээвэрлэнэ.

(б) Энэ зүйлийн (а)-гийн 1/-ийг үл харгалзан, эрэн хайх болон түргэн тусламжийн зорилгоор үйлдэх нислэгт, согтууруулах ундаа, эм тарианд мансуурсан, биеэ авч явах чадваргүй, агаарын хөлгийн болон зорчигчдын аюулгүй байдалд хор нөлөө үзүүлж болзошгүй аливаа этгээдийг тээвэрлэгчийн зүгээс шаардлагатай арга хэмжээ авсан тохиолдолд тээвэрлэж болно.

135.65. Нисэх багийн бүхээгт нэвтрэх

(а) Гэрчилгээ эзэмшигч нь, дор дурдсанаас бусад аливаа этгээдийг нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн нисэх багийн бүхээгт нэвтрэх, нисгэгчийн суудал эзлэхийг хориглоно:

- 1/ нисэх багийн гишүүн;
- 2/ гэрчилгээ эзэмшигч болон агаарын хөлгийн даргаас зөвшөөрөл олгогдсон, эсхүл албан үүргээ гүйцэтгэж байгаа этгээд.

135.67. Нислэгийн бичлэгийн хэрэгсэлд тавигдах шаардлага

(а) Нисэх багийн гишүүн бүр, энэ дүрмийн 135.263-д шаардсан бүхээгийн дуу чимээ бичигч (cockpit-voice recorder)-ийг:

- 1/ хөдөлгүүр асаахаас өмнө, шалгах хуудас уншихаас эхлэн, нислэг дуусах хүртэл тасралтгүй ажиллуулна;
- 2/ хэрэв нисдэг тэргийг чихэвчний болон гар микрофоноос бичих хэрэгслээр тоногдсон бол гар микрофоныг 3000 метр /10000 фут/-ээс нам өндөрт ашиглана;

- 3/ хэрэв бүхээгийн дуу чимээ бичигч нь бичлэг арилгагчтай бол нислэгийн сүүлчийн 30 минутын бичлэгээс өмнөх бичлэгийг арилгадаг байна гэдгийг бататгана.

(б) Нисэх багийн гишүүн бүр 135.265-д шаардсан, нислэгийн өгөгдөхүүн бичигч /flight data recorder/-ийг:

- 1/ нисдэг тэрэг хөөрөлт үйлдэхээс эхлэн буулт үйлдэх хүртэл тасралтгүй ажиллуулна;
- 2/ бичигдсэн өгөгдөхүүнүүдийг дараагийн 10 цагийн нислэг үйлдтэл хадгална;
- 3/ нислэгийн өгөгдөхүүн бичигч ба түүний бичлэгийг шалгахдаа бичигдсэн өгөгдөхүүний 1 цагаас илүү бичлэгийг арилгаж болохгүй;
- 4/ энэ хэсгийн 3/-т заасны дагуу бичлэг арилгахдаа:
 - 4.1 хамгийн хуучин бичлэгийг сонгоно;
 - 4.2 техник үйлчилгээний холбогдох бичиг баримтад тэмдэглэнэ.

135.69. Түлшээр сумлах, түлш юүлэх ажиллагаа

(а) Гэрчилгээ эзэмшигч нь, зорчигчдыг агаарын хөлөгт суулгаж, эсхүл агаарын хөлгөөс буулгаж байгаа, мөн үндсэн хөдөлгүүрүүдээс аль нэг нь ажиллаж байгаа үед 3(а) ангиллын түлшээр агаарын хөлгийг сумлах, эсхүл түлш юүлэх ажиллагааг гүйцэтгэж болохгүй.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь, зорчигчдыг агаарын хөлөгт суулгах, эсхүл агаарын хөлгөөс буулгах үед гэрчилгээ эзэмшигчийн холбогдох зааварт тусгасан журмын дагуу авран хамгаалах ажиллагааг гүйцэтгэж чадахгүй тохиолдолд 3(б) ангиллын түлшээр агаарын хөлгийг сумлах, эсхүл түлш юүлэх ажиллагааг гүйцэтгэж болохгүй.

(в) Гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлгийг түлшээр сумлах, эсхүл түлш юүлэх ажиллагааны үед гуравдагч этгээдэд хохирол учруулахаас сэргийлнэ.

135.71. Түлш асгарах

(а) Түлшээр сумлах, түлш юүлэх үед зөвшөөрөгдөөгүй гадаргуу дээр түлш асгарсны улмаас хүн болон эд зүйлд аюул учруулж болзошгүй бол нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа аливаа этгээд:

- 1/ түлшээр сумлах, эсхүл түлш юүлэх ажиллагааг зогсооно;
- 2/ асгарсан түлшийг элс, үртэс, хуурай шороо, хөөс болон химийн хуурай гал унтраагч нунтаг зэргээр хучих арга хэмжээг яаралтай авна.

135.73. Аэродромын ашиглалт

(а) Гэрчилгээ эзэмшигчийн нислэгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа аэродромын ил харааны хэрэгсэл, саадын хязгаарлалт, газар зүйн үндсэн өгөгдөхүүн нь:

- 1/ ашиглаж байгаа тухайн онгоцны үзүүлэлтүүдэд тохирсон байна;
- 2/ цаг уурын минимум нөхцөлөөр ашиглагддаг байна.

(б) Гэрчилгээ эзэмшигчийн ашиглаж байгаа нисдэг тэрэг нь ИНД-91-ийн шаардлагуудыг хангасан байна.

(в) Гэрчилгээ эзэмшигч нь AIP-д нийтлэгдээгүй аэродромд нислэг үйлдэх бол дараах бүртгэл, мэдээлэлтэй байна:

- 1/ тухайн аэродромын өгөгдөхүүн;
- 2/ аэродромын нөхцөл байдал тухайн нислэгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөхгүй гэдгийг бататгасан журам;
- 3/ аюулгүй ажиллагааны болон шаардлагатай бусад тоног төхөөрөмжүүдийн нөхцөл байдал тухайн нислэгийн аюулгүй үйл ажиллагаанд нөлөөлөхгүй гэдгийг бататгах журам;
- 4/ тухайн аэродромын ашиглалтын хязгаарлалт.

(г) Өдрийн цагт, ИХНД-ээр нислэг үйлдэх онгоцоор, дараах шаардлагыг хангаагүй талбайд хөөрөлт, буулт үйлдэж болохгүй:

- 1/ ашиглаж байгаа ХБЗ нь:
 - 1.1 онгоцны үндсэн тулгуурын гадна талын хоёр дугуйны хоорондох зайнаас хоёр дахин өргөн;
 - 1.2 хөөрөлт буулт үйлдэхэд тохиромжтой шулуун, зурвасны гадаргуу нь тэгш байна.
- 2/ ХБЗ-ны өргөн нь онгоцны далавчны дэлгэц /размах/-ээс 2.5 дахин болон түүнээс дээш, эсхүл 30 метрийн аль ихээр нь тогтоогдсон байна.

(д) Энэ зүйлийн (г)-гийн дагуу нислэг үйлдээгүй онгоц дараах тохиолдолд аливаа талбайд хөөрөлт, буулт үйлдэхгүй:

- 1/ ашиглах гэж буй онгоцны хувьд тухайн аэродромын лавлах код энэ дүрмийн Хавсралтын Хүснэгт 2-т тодорхойлогдоогүй бол;
- 2/ ХБЗ-ны өргөн нь Хавсралтын Хүснэгт 3-т заасан онгоцны кодын дугаараар тодорхойлогдох өргөнөөс бага бол;
- 3/ нислэгийн талбай /runway strip/-н хамгийн бага өргөн нь Хавсралтын Хүснэгт 4-т заасан лавлахаар тодорхойлогдоогүй бол.

(е) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (г) болон (д)-г үл харгалзан, аль нэг онгоцны маягийн хувьд (г) болон (д)-д тусгагдсанаас бага өргөнтэй ХБЗ-ыг дараах нөхцөлд ашиглаж болно:

- 1/ зурвасны хамгийн бага өргөнийг тухайн онгоцны Нислэгийн ашиглалтын зааварт заасны дагуу шалгах нислэгээр тодорхойлсон бол;
- 2/ зурвасны хамгийн бага өргөнийг ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрсөн бол.

135.75. Нэг хөдөлгүүртэй агаарын хөлгөөр ХНД-ийн дагуу нислэг үйлдэх

(а) Энэ дүрмийн дагуу нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа аливаа этгээд дараах шаардлагыг хангаагүй нэг хөдөлгүүртэй агаарын хөлгөөр ХНД-ийн дагуу зорчигч тээврийн нислэг үйлдэхгүй:

- 1/ ерөнхий шаардлага:
 - 1.1. үйлдвэрлэгчээс тухайн агаарын хөлгийг турбинт хөдөлгүүрээр тоногдсон бол;
 - 1.2. агаарын хөлгийн турбинт хөдөлгүүр нь 100000 цаг тутмын техник үйлчилгээний хувьд Mean time between Failure (MTBE) 01/1000 ба түүнээс бага байх шаардлагыг хангасан бол;
- 2/ тоног төхөөрөмжид тавигдах шаардлага:
 - 2.1 тусдаа цахилгаан тэжээл бүхий харилцан хамааралгүй 2ш авиагоризонтын хэрэглэлтэй байх;

- 2.2 цахилгаан тоноглол ба чухал хэрэглэлийг цахилгаан тэжээлээр хангах харилцан хамааралгүй цахилгааны хоёр эх үүсгүүртэй байх;
- 2.3 хөдөлгүүрийн авто асаагуур ба түүнтэй ижил системтэй байх ба гэрчилгээ эзэмшигчийн Нислэг үйлдвэрлэлийн зааварт “онгоцны хөөрөлт, буулт ба агаарын сэгсрэлттэй нислэгийн үед хөдөлгүүрийн асаагуурын системийг үргэлжлүүлэн ажиллах байдалд залгасан байна” гэж заасан байх;
- 2.4 хөдөлгүүрийн тосонд төмрийн үртэс бий болсныг илрүүлэн, нисэх багт дохиолох хэрэгсэлтэй байх;
- 2.5 радио өндрийн хэмжигчтэй байх;
- 2.6 хөдөлгүүр удирдах бариул нь хөдөлгүүрийн түлшийг удирдах хэсэгт, эсвэл блокт дутагдал гарсан үед түүнийг алгасан хөдөлгүүрийг үргэлжлүүлэн удирдах боломжтой байх;
- 2.7 агаарт хөдөлгүүр татгалзсан үед аюулгүй буулт үйлдэх боломж бүхий бүсэд нислэг үйлдэх;
- 2.8 ослын буулт үйлдэхэд тохиромжтой хамгийн ойрын аэродромыг тодорхойлж навигацийн тооцоо хийх боломжтой байх;
- 2.9 агаарын хөлгийн нисэж буй тухайн өндөрт хөдөлгүүр унтрах тохиолдолд далайн түвшний өндөр хүртэл тохиромжтой өнцгөөр гулгалт үйлдэхэд цахилгааны чухал шит болон автопилот, бусад тоноглолыг цахилгаан тэжээлээр хангах нөөц үүсгүүртэй байх;
- 2.10 нэг нисгэгчтэй агаарын хөлгийн хувьд гурван тэнхлэгийн удирдлага бүхий автопилоттой байх.

135.77. Үйл ажиллагааг хязгаарлах буюу түр зогсоох

(а) Гэрчилгээ эзэмшигч нь, нислэгийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдсэн тохиолдолд тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэлх хугацаанд нислэгийн үйл ажиллагаандаа хязгаарлалт хийх, эсхүл үйл ажиллагаагаа түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авна.

135.79. ИХНД /VFR/-ээр үйлдэх нислэгийн хамгийн бага өндөр

(а) Энэ зүйлийн дагуу нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн даргад ИНД-91-ийн холбогдох заалт хамаарахгүй.

(б) Арилжааны нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга нь дараах тохиолдолд ИНД-91-ийн холбогдох заалтыг үл харгалзан, ойртолт, хөөрөлт болон нислэгийн бусад маневрыг хүн, машин техник, барилга байгууламжаас 150 метр /500 фут/-ийн радиус дотор, гадаргуугаас дээш 150 метр /500 фут/-ээс нам өндөрт гүйцэтгэж болно:

- 1/ тухайн нислэгийн төлөвлөгөө нь, түүнд оролцох байгууллага, хүмүүсийн оролцоотойгоор хийгдсэн бол;
- 2/ нислэгийн үйл ажиллагаа нь аливаа хүн ба эд зүйлд аюул учруулахааргүй бол;
- 3/ энэ хэсгийн 1/-д заасан төлөвлөгөөний дагуу нислэгийн үйл ажиллагаанд оролцох байгууллага, хүмүүст мэдээлэл хийсэн бол.

135.81. Усан дээгүүрх нислэг

(а) Авторотацийн үед буух зай нь эргээс 18,6 км /10 nm/-ээс дээш тохиолдолд, усан дээгүүр нислэг үйлдэх аливаа этгээд дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ агаарын хөлөгт байгаа бүх хүмүүс багтахуйц аврах завьтай байна;
- 2/ зорчигч бүр аврах хантааз өмссөн байна;
- 3/ нислэгийн төлөвлөгөө хийгдсэн, эсхүл 135.55.-ийн (г), (д)-ийн дагуу нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжид танилцуулагдсан байна.

(б) Авторотацийн үед буух зай нь эргээс 18,6 км /10nm/-ээс дээш тохиолдолд, нэг хөдөлгүүрт нисдэг тэргээр усан дээгүүр нислэг үйлдэх аливаа этгээд дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ нисдэг тэрэг ажиллагаатай, хийлдэг төхөөрөмжөөр тоноглогдсон байна;
- 2/ нисдэг тэргэнд байгаа бүх хүмүүс аврах хантааз өмссөн байна.

(в) Олон хөдөлгүүрт агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн хувьд, энэ зүйлийн (а)-гийн 2/-ыг үл харгалзан, зорчигч бүр аврах хантааз ашиглах боломжтой байна.

(г) Эргээс планердаж, эсхүл авторотацийн тусламжтайгаар буух боломжгүй зайд алслагдсан нислэг гүйцэтгэх аливаа этгээд нь:

- 1/ НХУ-ний салбар нэгжтэй тохиролцсон нислэгийн төлөвлөгөөтэй байна;
- 2/ нислэгийг ХНД-ээр гүйцэтгэнэ.

135.83. Онцгой нөхцөл байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө

(а) Гэрчилгээ эзэмшигч нь, нислэгт болон газар дээрх онцгой нөхцөл байдлын үед хүмүүс гэмтэж бэртэх магадлалыг аль болох бууруулахад чиглэсэн онцгой нөхцөл байдлын үеийн арга хэмжээний төлөвлөгөөтэй байна.

(б) Энэ зүйлийн (а)-д заасан төлөвлөгөө нь дараах зүйлд үндэслэсэн байна:

- 1/ нислэгийн үйл ажиллагааны төрөл болон аяллын нийт зай /км/;
- 2/ аэродромын газрын хангалт, тоноглол;
- 3/ тухайн орон нутгийн авран хамгаалах үйлчилгээ;
- 4/ НХУ-ын хангалт, тоноглолууд;
- 5/ агаарын хөлгийн маяг, суудлын тоо, төлбөрт ачаалал.

(в) Гэрчилгээ эзэмшигч нь нислэг дэх онцгой нөхцөл байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөнд дараах зүйлүүдийг тусгасан байна:

- 1/ нислэгт үүссэн онцгой нөхцөл байдлын үед арга хэмжээ авах, шийдвэр гаргах эрх бүхий этгээд нь дараах зүйлийг бататгана:
 - 1.1 үүссэн онцгой нөхцөл байдлын талаар агаарын хөлгийн даргад мэдээлэл, зөвлөмж өгөгдсөн эсэхийг;

- 1.2 агаарын хөлгийн даргын шийдвэр зөв зүйтэй эсэхийг;
- 1.3 шийдвэрийн талаар бичлэг, тэмдэглэл хийгдсэн эсэхийг.

- 2/ энэ хэсгийн 1/-д заасны дагуу агаарын хөлгийн даргатай холбоо тогтоож чадаагүй тохиолдолд шийдвэр гаргах эрх бүхий этгээд нь дараах зүйлийг бататгана:
 - 2.1 авран хамгаалах ажиллагаа зарлагдсаныг;
 - 2.2 тухайн нөхцөл байдалд шаардлагатай арга хэмжээ авагдаж байгааг.

(г) Гэрчилгээ эзэмшигч нь, онцгой нөхцөл байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу холбогдох хүмүүсийг шаардлагатай сургалтад хамруулсныг, мөн сургалтад хамрагдсан хүмүүс нь зохих ажиллагааг хэрэгжүүлэх чадвартай гэдгийг бататгана.

135.85. Хүн ам шигүү суурьшсан газар нутаг дээгүүрх нислэг

(а) ИНД-91-ийн холбогдох заалтыг үл харгалзан, нисдэг тэрэгний дарга нь хүн ам шигүү суурьшсан газар нутаг дээгүүр, хамгийн өндөр аливаа саадаас дээш 300 м /1000 фут/-ээс нам өндөрт, нисдэг тэрэгнээс 600 м /2000 фут/-ийн радиус дотор, дараах шаардлагыг хангасан нөхцөлд нислэг үйлдэж болно:

- 1/ дараах зүйлийг тусгасан нислэгийн төлөвлөгөөтэй:
 - 1.1 нислэгийн өндөр болон нислэг үйлдэх газар нутгийг тэмдэглэсэн зурагтай;
 - 1.2 хүн болон эд зүйлд хохирол учруулахгүй байхыг баталгаажуулсан журамтай;
 - 1.3 НХҮ-ний байгууллагад зайлшгүй шаардлагатай мэдээллүүдийг өгсөн;
 - 1.4 тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад албан ёсоор мэдэгдэж, орон нутгийн эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг дагаж мөрдөх бол;
- 2/ тухайн нислэгийн үйл ажиллагаанд оролцох бүх байгууллага, хүмүүс энэ хэсгийн 1/-д заасан нислэгийн төлөвлөгөөтэй танилцсан байна;
- 3/ нислэгийн төлөвлөгөөг, нислэг үйлдсэн өдрөөс хойш 12 сараас доошгүй хугацаагаар хадгална.

(б) Энэ зүйлийн (а)-гийн дагуу нислэгийн үйл ажиллагаанд оролцсон агаарын хөлгийн дарга нь (а)-гийн 1/-д заасан нислэгийн төлөвлөгөөг дагаж мөрдөнө.

135.87. Нисдэг тэрэгний татлагат ачаалал

(а) Нисдэг тэргээр агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа агаарын хөлгийн дарга нисдэг тэрэгний гадна татлагат ачаалал хийхийг хориглоно.

(б) Нисдэг тэргээр арилжааны нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа агаарын хөлгийн дарга ИНД-133-ын шаардлагыг үл харгалзан, дараах тохиолдлуудад нисдэг тэрэгний гадна татлагат ачааллаар ачаа зөөвөрлөж болно:

- 1/ татлагат ачааллаар зөөвөрлөх ачаа нь агаарын хөлгийн бүхээгт байгаа зорчигчдынх бол;
- 2/ ИНД-133-т заасан, гадна ачаалалтай нисдэг тэрэгний нислэгийн үйл ажиллагааны шаардлагуудыг хангаж байгаа бол;
- 3/ нислэг нь өдрийн цагаар, ИХНД-ийн дагуу үйлдэгдэж байгаа бол;
- 4/ тухайн нисдэг тэрэг нь хөөрөлт буултын үеийн хамгийн их боломжит чадлаас 10%-иас доошгүй чадлын хязгаарт ажиллаж байгаа бол.

В БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯЗГААРЛАЛТ БОЛОН ЦАГ УУРЫН ШААРДЛАГУУД**135.101. Цаг уурын мэдээ**

(а) Нислэгийг ИХНД-ийн дагуу гүйцэтгэж байгаа этгээд нь тухайн нислэгт зориулан гэрчилгээ эзэмшигч болон агаарын хөлгийн даргад өгөгдсөн цаг уурын мэдээг ашиглан нислэгийг төлөвлөж, гүйцэтгэж, хянана.

(б) ХНД-ийн дагуу гүйцэтгэх этгээд нь ИНД-174-ийн дагуу гэрчилгээ эзэмшигчээс авсан цаг уурын мэдээг ашиглан нислэгийг төлөвлөж, гүйцэтгэж, хянана.

(в) Монгол Улсын нутаг дэвсгэр дээр, ХНД-ийн дагуу үйлдэгдэж буй нислэгийн хувьд агаарын хөлгийн дарга нь буух ойртолт болон буулт үйлдэхдээ ИНД-174-ийн дагуу хангагдах цаг агаарын үндсэн илтгэлийг ашиглаж болно.

135.103. ИХНД-ээр нислэг үйлдэх цаг уурын нөхцөл

(а) ИХНД-ээр нислэг үйлдэх замын дагуух, эсхүл тухайн нислэгийн замын тодорхой хэсэг дэх цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээнд, энэ зүйлийн (б), (в), (г), (д) болон ИНД-91-д заасан ИХНД-ийн хязгаарлалт хангагдаагүйг заасан бол агаарын хөлгийн дарга ИХНД-ээр нислэг үйлдэхгүй.

(б) Агаарын хөлгийн дарга, хяналттай агаарын зайн гадна, цаг уурын дараах нөхцөлүүдэд ИХНД-ээр нислэг үйлдэж болно:

- 1/ газрын гадаргуугаас дээш 300 м /1000 фут/-ээс доошгүй өндөрт, алсын барааны харагдац 5 км-ээс багагүй байх үед;
- 2/ хэрэв шөнийн нислэг үйлдэж байгаа бол, газрын гадаргуугаас дээш 900 м /3000 фут/-ээс доошгүй өндөрт, алсын барааны харагдац 16 км-ээс багагүй байх үед.

(в) Агаарын хөлгийн дарга, хяналттай агаарын зайн гадна нисдэг тэргээр, цаг агаарын дараах нөхцөлд ИХНД-ээр нислэг үйлдэнэ:

- 1/ газрын гадаргуугаас дээш 200м /600 фут/-ээс доошгүй өндөрт, алсын барааны харагдац 1500 м-ээс багагүй байх үед;
- 2/ хэрэв шөнийн цагаар нислэг үйлдэж байгаа бол, газрын гадаргуугаас дээш 600 м /2000 фут/-ээс доошгүй өндөрт, алсын барааны харагдац 5 км-ээс багагүй байх үед.

(г) Нисдэг тэргээр, ИХНД-ээр арилжааны нислэг үйлдэх агаарын хөлгийн дарга нь:

- 1/ нислэгийн маневруудыг үйлдэхдээ өөр бусад агаарын хөлгийн хөдөлгөөнийг ажиглан, аливаа саадтай мөргөлдөхөөс сэргийлнэ;
- 2/ нислэгийг дараах нөхцөлд үйлдэнэ:
 - 2.1 алслагдсан аэродромын хувьд, газрын гадаргуугаас дээш 200 м /600 фут/-ээс доошгүй өндөрт, алсын барааны харагдац 1500 м-ээс багагүй байх цаг агаарын нөхцөлд;
 - 2.2 алслагдсан аэродромоос бусад аэродромын хувьд, нислэгийн хамгийн дээд өндрөөс доош, газрын гадаргуу харагдахуйц өндөрт/сэмжин үүлнээс бага үүлний дээгүүр/;
 - 2.3 хэрэв шөнийн нислэг үйлдэж байгаа бол, газрын гадаргуугаас дээш 600м /2000 фут/-ээс доошгүй өндөрт, алсын барааны харагдац 5 км-ээс багагүй байх нөхцөлд.

(д) Агаарын хөлгийн дарга, дараах шаардлагуудыг хангаагүй тохиолдолд сэмжин үүлний дээгүүр ИХНД-ээр нислэг үйлдэхгүй:

- 1/ агаарын хөлөг нь ХНД-ээр нислэг үйлдэх шаардлагыг хангасан ба нисэх баг нь хэрэглэлийн нислэгийн хүчин төгөлдөр зэрэглэлтэй байх /нислэгт шаардагдах хамгийн цөөн бүрэлдэхүүнтэй нисэх баг болон ХНД-ийн дагуух нислэгт тавих шаардлагуудыг хангасан/;
- 2/ ХНД-ээр үйлдэх нислэгт шаардлагатай радио навигацийн болон бусад хэрэглэл, тоног төхөөрөмжүүд нь ажиллагаатай байх;
- 3/ агаарын хөлөг нь, хэрэглэлийн тусламжтайгаар ойртолт үйлдэн буух боломжтой аэродром руу ХНД-ээр нислэгийг чиглүүлэх радио навигацийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх;
- 4/ агаарын хөлөг нь, хэрэглэлийн тусламжтайгаар ойртолт үйлдэн буух аэродром руу нисэх хангалттай түлштэй байх.

(е) Агаарын хөлгийн дарга нь энэ дүрмийн 135.75-д зааснаас бусад тохиолдолд, нэг хөдөлгүүрт агаарын хөлгөөр, сэмжин үүлнээс дээш өндөрт ИХНД-ээр зорчигч тээврийн нислэг үйлдэхгүй.

135.105. ХНД-ээр нислэг үйлдэх цаг уурын нөхцөл

(а) Нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх агаарын хөлгийн дарга нь, нисэн очихоор төлөвлөсөн аэродромд, тооцоот цагт нисэн очих үеийн цаг агаарын бодит мэдээ, эсхүл урьдчилсан ба бодит мэдээний багцад заагдсан цаг агаарын нөхцөл нь ИНД-95-д заасан, хэрэглэлээр ойртолт үйлдэх минимумд болон түүнээс дээш биш бол ХНД-ээр нислэг үйлдэхгүй.

135.107. Аэродромын минимум - ХНД-ээр үйлдэх нислэг

(а) Буултын ойртолтын төгсгөлийн цэг, эсхүл буултын ойртолтын төгсгөлийн үе шатыг өнгөрөхөөс өмнө тухайн аэродромын орчны харагдац нь хэрэглэлээр ойртолт үйлдэх журмын хувьд ИНД-95-д заасан орчны харагдацаас доогуур байгааг тухайн үеийн цаг уурын мэдээнд заасан бол агаарын хөлгийн дарга хэрэглэлийн тусламжтайгаар буултын ойртолтыг үргэлжлүүлж болохгүй.

(б) Энэ дүрмийн хувьд, буултын ойртолтын төгсгөлийн үе шат:

- 1/ буултын ойртолтын төгсгөлийн цэгээс, эсхүл хэрэглэлийн тусламжтайгаар буултын ойртолт үйлдэх журамд заагдсан байгууламжаас;
- 2/ буултын ойртолтын төгсгөлийн цэг тусгайлан заагдаагүй тохиолдолд онгоц, буулт үйлдэх журамд заасан зайд эргэлтийг бүрэн гүйцэтгэн буултын чиглэлд орох цэгээс тус тус эхэлнэ.

135.109. ХНД-ээр хөөрөлт үйлдэх хязгаарлалтууд

(а) Цаг уурын нөхцөл нь ИНД-91-д заасан хөөрөлтийн минимумд, эсхүл түүнээс дээгүүр болон ИНД-91-д заасан ХНД-ээр буулт үйлдэх зөвшөөрөгдсөн минимумаас доогуур бол дараах тохиолдолд тухайн аэродромоос ХНД-ээр хөөрөлт үйлдэхгүй:

- 1/ хоёр хөдөлгүүрт агаарын хөлгийн хувьд, агаар тогтуун байх үед нэг хөдөлгүүр татгалзсан үеийн чиг шулуун нислэгийн хурдтайгаар, хөөрөлт үйлдсэн аэродромоос нислэгийн нэг цагаас дээш хугацаагаар нисэх бол;
- 2/ гурав, эсхүл олон хөдөлгүүрт агаарын хөлгийн хувьд, агаар тогтуун байх үед нэг хөдөлгүүр татгалзсан үеийн чиг шулуун нислэгийн хурдтайгаар, хөөрөлт үйлдсэн аэродромоос нислэгийн хоёр цагаас дээш хугацаагаар нисэх бол.

135.111. Багасгасан горимоор хөөрөлт үйлдэх минимум

(а) Гэрчилгээ эзэмшигч нь, багасгасан горимоор хөөрөлт үйлдэх журмыг өөрийн заавартаа заасан тохиолдолд ИНД-91-д заасан хөөрөлтийн минимумаас бага горимоор хөөрөлтийг гүйцэтгэж болно.

(б) Багасгасан горимоор хөөрөлт үйлдэх журамд дараах зүйлийг бататгасан байна:

- 1/ нисэх багийн гишүүд хөөрөлтийн багасгасан горимоор хөөрөлт үйлдэх минимумд бэлтгэгдсэнийг;
- 2/ ашигладаг ХБЗ нь тэнхлэгийн голчийн тэмдэглэгээтэй, эсхүл тэнхлэгийн гол шугам нь гэрэлтдэг байх;
- 3/ ашигладаг ХБЗ-аас багасгасан горимоор хөөрөлт үйлдэх минимум нь ИНД-95-ын дагуу зөвшөөрөгдсөн байх;
- 4/ агаарын хөлөг нь сэнст хоёр хөдөлгүүртэй бол автомат флюгер, эсхүл сэнсний өнцгийг автоматаар өөрчлөх системээр тоноглогдсон гэдгийг;
- 5/ ХБЗ-ны харагдац нь, Зурвасны дагуух алсын барааны харагдац /RVR/- аар тогтоогдсон байх;
- 6/ хөөрөлт үйлдэхэд шаардлагатай харагдацыг тодорхойлох, хянах аргачлал нь ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрөхүйц байна.

135.113. ХНД-ээр нислэг үйлдэх

(а) Агаарын хөлгийн дарга нь дор дурдсанаас бусад тохиолдолд, маршрутын нислэгт ИНД-95-д заасан ХНД-ийг мөрдөнө:

- 1/ бодит аюулаас зайлсхийх зайлшгүй шаардлага тулгарсан үед, эсхүл
- 2/ НХУ-ний радиолокаторын хяналтан дор нислэг үйлдэх үед, эсхүл
- 3/ НХУ-ний нэгжийн зөвшөөрлийн дагуу маршрутын бус нислэг үйлдэж байгаа үед, эсхүл
- 4/ гэрчилгээ эзэмшигчийн батлагдсан зааварт өөрөөр тодорхойлогдсон бол.

(б) Холбогдох НХУ-аас хяналттай агаарын зайд нислэг үйлдэх зөвшөөрөл олгогдоогүй бол агаарын хөлгийн дарга нь тухайн аэродромын хувьд ИНД-95-ын дагуу ХНД-ээр хөөрөлт болон буултын ойртолт үйлдэх журмуудыг дагаж мөрдөнө.

(в) Хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлгийн дарга нь ИНД-95-ын дагуу ХНД-ээр хөөрөлт ба ойртолт үйлдэх журмуудыг дагаж мөрдөнө.

Г БҮЛЭГ. НИСЛЭГ, ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

135.151. Зорилго

(а) Энэ зүйлийн (б), (в) ба (г)-д зааснаас бусад тохиолдолд, нислэгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа онгоцны нислэг, техникийн үзүүлэлтэд тавих хязгаарлалтууд энэ бүлэгт тусгагдсан болно.

(б) Энэ дүрмийн 135.179.-135.185-р зүйл нь дараах нөхцөлөөр гэрчилгээжсэн сэнст онгоцонд хамаарахгүй:

- 1/ АНУ-ын иргэний нисэхийн стандарт FAR 23-ын хэвийн ангилал, эсхүл түүнтэй адил төстэй НТЧ-ын стандартууд, эсхүл
- 2/ АНУ-ын иргэний нисэхийн стандарт SFAR 23-ын НТЧ-ын стандартууд, эсхүл түүнтэй адил төстэй стандартууд.

(в) Энэ дүрмийн 135.157, 135.161, 135.171, 135.173-р зүйлийн заалтууд нь дараах нөхцөлөөр гэрчилгээжсэн сэнст онгоцонд хамаарахгүй:

- 1/ АНУ-ын иргэний нисэхийн стандарт SFAR 41-ийн стандартууд, эсхүл түүнтэй адил төстэй НТЧ-ын стандартууд, эсхүл
- 2/ АНУ-ын иргэний нисэхийн стандарт FAR 23-ын commuter ангиллын НТЧ-ын стандартууд, эсхүл түүнтэй адил төстэй НТЧ-ын стандартууд, эсхүл
- 3/ энэ дүрмийн Хавсралт А-д заагдсан НТЧ-ын стандартууд.

(г) Энэ бүлгийн шаардлагыг бүрэн хангахгүй онгоцыг ашиглалтын хязгаарлалтын нэмэлт үзүүлэлтийн дагуу нислэг үйлдэхийг зөвшөөрч болно.

(д) Энэ дүрмийн 135.161, 135.169-р зүйлүүд нь 135.75-ын дагуу ХНД-ээр нислэг үйлдэх агаарын хөлөгт хамаарахгүй.

135.153. Нислэг, техникийн үзүүлэлтийг мөрдөх

(а) Нислэгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа онгоц нь АНУ-ын иргэний нисэхийн стандарт FAR Part 25-ын НТЧ-ын стандарт, эсхүл түүнтэй адил чанарын НТЧ-ын стандартын дагуу гэрчилгээжсэн бол Гэрчилгээ эзэмшигч ИНД-121-д заасан нислэгийн үзүүлэлт, ашиглалтын хязгаарлалтуудыг дагаж мөрдөнө.

135.155. Онгоцны ерөнхий үзүүлэлт

(а) Гэрчилгээ эзэмшигч нь, нислэгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа онгоцны хувьд дараах зүйлийг бататгана:

- 1/ хөөрөхийн өмнөх хөөрөлтийн жин, төвлөрөлт нь тухайн нислэгийн хувьд, энэ бүлгийн дагуу зөвшөөрөгдсөн жингээс илүүгүйг;
- 2/ энэ бүлэгт заасан үзүүлэлтийн шаардлагуудыг хангаж буйг тодорхойлоход ашиглагдах өгөгдөхүүнүүд нь:
 - 2.1 тухайн онгоцны Нислэгийн ашиглалтын зааварт тусгагдсаныг, эсхүл
 - 2.2 бохирдсон (contaminated) ХБЗ-ын буултын зайн өгөгдөхүүнүүдийн хувьд тухайн онгоцыг үйлдвэрлэгчээс тогтоогдсон ба ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрснийг.

135.157. Хөөрөлтийн зай

(а) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа онгоцны хувьд дараах зүйлийг бататгана:

- 1/ тухайн онгоцны Нислэгийн ашиглалтын зааварт заасан хөөрөлтийн хамгийн их жин болон төвлөрөлтийг хэтрүүлэхгүйг;
- 2/ хөөрөлт үйлдэхэд шаардлагатай зай нь хөөрөлтийн гүйлтийн боломжит зайн 85 %-иас хэтэрч болохгүйг.

(б) Энэ зүйлийн (а)-д заасан хөөрөлтийн зай болон жинг тооцоолохдоо гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлүүдийг харгалзана:

- 1/ хөөрөлтийн гүйлтийн боломжит зай;
- 2/ хөөрөлт үйлдэхээс өмнөх онгоцны хөөрөлтийн жин болон төвлөрөлт;
- 3/ хөөрөлт үйлдэх аэродромын өндөр /даралтаар/;
- 4/ аэродром орчмын агаарын температур;
- 5/ ХБЗ-ны гадаргуугийн төрөл, байдал;
- 6/ хөөрөлт үйлдэх чиглэл дэх зурвасны налуу;
- 7/ эсэргүүцэх салхины векторын 50 %-иас ихгүй, эсхүл арын салхины векторын 150 %-иас багагүй байх.

135.159. ХБЗ-ны гадаргуу болон налуу тооцоолох хүчин зүйлүүд

(а) Онгоцны үзүүлэлтийн өгөгдөхүүнүүдийг өөр хэлбэрээр зөвшөөрөх боломжгүй бол Гэрчилгээ эзэмшигч нь ХБЗ-ны гадаргуугийн төрлөөс хамаарч 135.157-ийн (б)-гийн 5/, эсхүл 135.179-ийн (в)-гийн 4/-ийн дагуу тооцоолсон хөөрөлтийн зай, 135.171-ийн (в)-гийн 3/ ба 135.183-гийн (в)-гийн 3/-ын дагуу тооцоолсон буултын зайг дараах байдлаар засварлан тооцно :

- 1/ ХБЗ-ны өөр төрлийн гадаргуугийн хувьд Хүснэгт 1-д үзүүлсэн хүчин зүйлээр өөрчлөлт хийнэ;
- 2/ зурвасны налууны хувьд дараах байдлаар тооцон өөрчлөлт хийнэ:
 - 2.1 өгсүүр налуу 3% хүртэл тооцохдоо 1% тутамд хөөрөлтийн зайг 5%-иар ихэсгэнэ;
 - 2.2 өгсүүр налуу 3% хүртэл тооцохдоо 1% тутамд буултын зайг 5%-иар багасгана;
 - 2.3 газрын уруу налуу 3% хүртэл тооцохдоо 1% тутамд хөөрөлтийн зайг 5%-иар багасгана;
 - 2.4 газрын уруу налуу 3% хүртэл тооцохдоо 1% тутамд буултын зайг 5%-иар ихэсгэнэ.

Хүснэгт 1.

| Гадаргуугийн төрөл | Хөөрөлтийн зай | Хөөрөлтийг зогсоох зай | Буултын зай |
|--------------------|----------------|------------------------|-------------|
| Засмал | х 1.00 | х 1.00 | х 1.00 |
| Засагдаагүй хөрс | х 1.08 | х 1.14 | х 1.16 |
| Засагдсан хөрс | х 1.14 | х 1.20 | х 1.18 |

135.161. Хөөрөлт, гаралтын бүдүүвч - ХНД-ээр нислэг үйлдэх онгоц

(а) Гэрчилгээ эзэмшигч нь хоёр, эсхүл түүнээс олон хөдөлгүүртэй онгоцоор ХНД-ээр нислэг үйлдэх тохиолдолд онгоцны эрсдэлтэй хөдөлгүүр (critical engine) татгалзсанд тооцож хөөрөлт үйлдэх зурвасны дагуу 15м /50 фут/-ээс дээш өндөрт аливаа саад байхгүй гэдгийг бататгана.

(б) Хөөрөлтийн зурвасны хажуугаас саад хүртэлх зай дараах хэмжээнээс бага тохиолдолд аливаа саадыг хөөрөлт үйлдэх зурвасанд байна гэж тооцно:

- 1/ хөөрөлтийн үед нислэгийн чиглэлийг 15 градусаас ихээр өөрчлөх шаардлагагүй үед:

- 1.1 хөөрөлт үйлдэн өндөр авах чиглэлд саад хүртэл 45м + 0.10D зайд буюу 600м хүртэл, эсхүл онгоц ил харааны буюу радио навигацийн нислэгийн журмаар нисэж байгаа бол 300 м хүртэл;
 - 1.2 өдрийн цагт VMC /ил хараагаар нислэг үйлдэх цаг агаарын нөхцөл/-ээр үйлдэх нислэгийн хувьд хөөрөлт үйлдэн өндөр авах хөндлөн чиглэлд саад хүртэл 30 м + 0.10D зайд буюу 600 м хүртэл, эсхүл онгоц ил харааны буюу радио навигацийн нислэгийн журмаар нисэж байгаа бол 300м хүртэл;
- 2/ хөөрөлтийн үед нислэгийн чиглэлийг 15 градусаас ихээр өөрчлөх шаардлагатай үед:
- 2.1 хөөрөлт үйлдэн өндөр авах хөндлөн чиглэлд саад хүртэл 45м +0.10D зайд буюу 900 м хүртэл, эсхүл онгоц ил харааны буюу радио навигацийн журмаар нисэж байгаа бол 600м хүртэл;
 - 2.2 өдрийн цагт VMC-ээр үйлдэх нислэгийн хувьд хөөрөлт үйлдэн өндөр авах хөндлөн чиглэлд саад хүртэл 30 м+0.10D зайд буюу 600 м хүртэл, эсхүл онгоц ил харааны буюу радио навигацийн журмаар нисэж байгаа бол 300 м хүртэл.
- (D- хөөрөлтийн боломжит зайн төгсгөл /онгоц хөөрч өндөр аван 15м-т хүрэх цэг/-өөс саад хүртэлх хэвтээ зайн хэмжээ.)*
- (в) Энэ зүйлийн (а)-д заасны дагуу хөөрөлт гаралтын бүдүүвчийг тооцохдоо гэрчилгээ эзэмшигч:
- 1/ дараах үзүүлэлтүүдийг тооцсон байна:
 - 1.1 хөөрөлтийн гүйлтийн эхлэл дэх хөөрөлтийн жин;
 - 1.2 аэродромын өндөр;
 - 1.3 атмосферын даралт олон улсын стандарт атмосферээс 1%-иас илүү өөрчлөгдөж буй тохиолдолд аэродромын даралтаар тооцоологдох өндөр;
 - 1.4 аэродром орчмын гадна агаарын хэм;
 - 1.5 эсэргүүцэх салхины векторын 50%-иас ихгүй, эсхүл арын салхины вектор 150 %-иас багагүй байх.
 - 2/ хөөрөлтийн гадаргуугаас дээш 15м /50 фут/-ийн өндөрт хүрэхээс өмнө чиглэлийг 15 градусаас их хэмжээгээр өөрчлөхгүй;
 - 3/ ИНЕГ-аас зөвшөөрөөгүй бол:
 - 3.1 хөөрөлтийн гадаргуугаас дээш 15м /50 фут/-ийн өндөрт хүрэхээс өмнө кренийг 15 градусаас хэтрүүлэхгүй;
 - 3.2 хөөрөлтийн гадаргуугаас дээш 120м /400 фут/ хүртэлх өндөрт крен хийх өнцгийг 20 градусаас хэтрүүлэхгүй;
 - 3.3 хөөрөлтийн гадаргуугаас дээш 120м /400 фут/-ээс дээш өндөрт кренийг 25 градусаас хэтрүүлэхгүй.
 - 4/ зөвшөөрлийг дараах зүйлүүдийг үндэслэн олгоно:
 - 4.1 нислэгийн зам ба хурдад крений үзүүлэх нөлөө;
 - 4.2 нислэгийн хурдыг ихэсгэснээс үүсэх зайн өөрчлөлт;
 - 4.3 энэ дүрмийн 135.115-ын дагуу хийгдэх өндөр авалтын градиентын алдагдал ба онгоцны уналтын хязгаарын хадгалалт.

135.163. Хөдөлгүүрийн татгалзал - градиент ба онгоцны уналтыг засах

(а) Гэрчилгээ эзэмшигч нь онгоцны үзүүлэлтийн өгөгдөхүүнүүд хангалтгүй тохиолдолд энэ дүрмийн 135.163-ын (г)-гийн 4/-ийн 4.3-г дагаж мөрдөх үүднээс өндөр авалтын градиентын алдагдлыг Хүснэгт 2-т заасан үзүүлэлтээр тооцоолж хурдны уналтаас болж онгоц унах хязгаарыг хадгална.

Хүснэгт 2.

| Эргэлт /bank/-ийн өнцөг | Хурдны өөрчлөлт | Градиентын өөрчлөлт |
|-------------------------------|--------------------|--|
| 15° - 19° | V_2 | 1 x Онгоцны Нислэг ашиглалтын заавар 15° градиент алдагдал |
| 20° - 24° | V_2+15 knots | 2 x Онгоцны Нислэг ашиглалтын заавар 15° градиент алдагдал |
| 25° | V_2+19 knots | 3 x Онгоцны Нислэг ашиглалтын заавар 15° градиент алдагдал |

135.165. Чиг шулуун нислэгийн үед эрсдэлтэй хөдөлгүүр (critical engine) татгалзах

(а) Гэрчилгээ эзэмшигч нь хоёр, эсхүл түүнээс олон хөдөлгүүртэй онгоц бүрийн хувьд, тухайн онгоц нь аюулгүй хамгийн нам өндөр ба түүнээс дээш өндөр дахь эерэг налуу /positive slope/-д дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд нислэг гүйцэтгэх шаардлага хангагдсан аэродромоос дээш 300м /1000 фут/-ийн өндөрт нислэгийг үргэлжлүүлэх боломжтой эсэхийг бататгана:

- 1/ урьдчилан таамагласан цаг агаарын нөхцөл байдлууд тухайн нислэгт тооцоологдсон;
- 2/ хөдөлгүүр татгалзсан;
- 3/ ажиллагаатай үлдсэн хөдөлгүүрүүд нь хамгийн их чадлын горимоор ажиллаж байгаа.

(б) Чиг шулуун нислэгийн хязгаарлалтуудыг энэ зүйлийн (а)-гийн дагуу тооцоолохдоо гэрчилгээ эзэмшигч дараах зүйлийг бататгана:

- 1/ бүх хөдөлгүүрүүд нь тухайн онгоцны Нислэг ашиглалтын зааварт тодорхойлсон хамгийн их чадлын горимоор ажиллаж байгаа үед өндөр авалтын хурд нь 1 минутад 90м /300 фут/-ээс багагүй байх өндрөөс дээш өндөрт тухайн онгоцыг нисэж байна гэж тооцохгүйг;
- 2/ нэг хөдөлгүүр татгалзсан гэж үзэх чиг шулуун нислэгийн градиент нь gross-gradient-minus 0.5% байхыг.
- 3/ тухайн маршрутын аль ч цэгт нэг хөдөлгүүр татгалзсан нөхцөлд ойролцоо аэродромд буух боломжтой эсэх. Нам өндөрт саадыг аюулгүй давж тухайн аэродромд аюулгүй буулт үйлдэж зурвасанд бүрэн зогсоох.

135.167. Нислэгийн 90 минутын хязгаарлалт

(а) Гэрчилгээ эзэмшигч нь хоёр хөдөлгүүрт онгоцоор, тухайн онгоцны Нислэг ашиглалтын зааварт тусгагдсан үзүүлэлтүүд болон тооцоот буултын жинд нийцсэн аэродромоос 90 минутаас дээшгүй зайд нислэг үйлдэнэ.

(б) Энэ зүйлийн (в)-д зааснаас бусад тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь гурав болон түүнээс дээш хөдөлгүүртэй онгоцоор, тухайн онгоцны Нислэг ашиглалтын зааварт тусгагдсан үзүүлэлтүүд болон тооцоот буултын жинд нийцсэн аэродромоос 90 минутаас дээшгүй зайд нислэг үйлдэнэ.

(в) Гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд гурав болон түүнээс дээш хөдөлгүүртэй онгоцоор, тухайн онгоцны Нислэг ашиглалтын зааварт тусгагдсан үзүүлэлтүүд болон тооцоот буултын жинд нийцсэн аэродромоос 90 минутаас дээш зайд нислэг үйлдэж болно:

- 1/ нислэгт хоёр хөдөлгүүр татгалзах үеийн нислэгийн замын өгөгдөхүүнүүд нь тухайн онгоц, тооцоолсон цаг агаарын нөхцөл байдалд хоёр хөдөлгүүр нэгэн зэрэг татгалзах цэгээс татгалзсан хоёр хөдөлгүүртэйгээр буулт үйлдэх журмыг мөрдөн буулт үйлдэх аэродром хүртэл нислэгээ үргэлжлүүлэх боломжийг бүрдүүлсэн;
- 2/ хэрэв нислэгийн чиглэл дэх цаг агаарын нөхцөл байдал нь мөстөлтөөс хамгаалах системийн ажиллагааг шаардаж байгаа бол:
 - 2.1. нислэгийн чиглэл дэх хамгийн бага аюулгүй өндөрт эерэг налуу (positive slope)-тай, эсхүл
 - 2.2. градиент нь gross-gradient-minus 0.5% байх үеийн болон нислэгийн чиглэл дэх хамгийн эрсдэлтэй хэсэгт хоёр хөдөлгүүр татгалзсан гэж үзэн энэ зүйлийн (г)-д зааснаас бусад тохиолдолд, нислэгийн маршрутын дагуу 18.6км (10nm)-ийн доторх бүх саад ба уулархаг бүсээс 600м (2000 фут)-ийн босоо зайд аливаа саадгүй;
- 3/ хоёр хөдөлгүүр татгалзсаны дараа буулт үйлдэх аэродромын дээр 450м /1500 фут/-ийн өндөрт нислэгийн зам нь эерэг налуу /positive slope/-тай;
- 4/ хоёр хөдөлгүүр татгалзсан гэж тооцож буй цэг дэх онгоцны жин нь, буулт үйлдэхээр төлөвлөж буй аэродромд хүрэх хангалттай түлштэй ба тухайн аэродромын дээр наад зах нь 450м /1500 фут/-ийн өндөрт нисэн ирэх ба нисэн ирсний дараа 15 минутын турш нислэг үйлдэх боломжтой жингээс багагүй.

(в) Хэрэв нисгэгч радио навигацийн хэрэглэл ашиглах боломжтой бол чиглэлийг 9.3 км /5nm/ хязгаарт хадгалах ба энэ зүйлийн (в)-гийн 2-ын 2.2-т заасан 18.6 км /10nm/ зайг 9.3 км /5nm/ хүртэл багасгаж болно.

(г) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (в)-гийн шаардлагад нийцүүлэн тооцоо хийхдээ, цаг агаар тогтуун үед, агаарын стандарт хэмд, хөдөлгүүрийн чадал нь чиг шулуун нислэгийн хурдтай байх үед нислэгийн замын дагуу буулт үйлдэж болох аэродромоос 90 минутаас дээш зайд, нислэгийн маршрутын хамгийн эрсдэлтэй цэгт онгоцны 2 хөдөлгүүр татгалзсанд тооцно.

135.169. Буултын өндөр авалт - нисэн очих болон нөөц аэродром

(а) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа онгоцны хувьд дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ тооцоот цагт нисэн очих аэродром болон нөөц аэродромд буулт үйлдэх үеийн гадна агаарын хэм, аэродромын өндрийг тооцсон онгоцны буултын жин нь ойртолт ба буултын үед өндөр авах хамгийн их жингээс илүүгүй байна;
- 2/ 60м (200 фут)-ээс доош шийдвэр гаргах өндөртэйгээр, хэрэглэлийн тусламжтайгаар ойртолт үйлдэх үед эрсдэлтэй хөдөлгүүр (critical engine) татгалзсан гэж үзэн хоёрдугаар тойрогт гарах үед нислэгт зарцуулагдах түлшийг тооцсон тухайн онгоцны ойртолтын болон хөөрөлтийн хүнд нь өндөр авах дараах градиентэд тохирч байна:
 - 2.1 2.5%-иас доошгүй, эсхүл
 - 2.2 135.161-ын дагуу ойртолтоос хоёрдугаар тойрогт гарах нислэгийн зам дахь аливаа саадыг тойрч гарах шаардлагатай өндөр авалтын градиент.

135.171. Буултын зай - хуурай зурвас

(а) Гэрчилгээ эзэмшигч нь ашиглаж буй онгоцныхоо төлөвлөсөн цагт буух үеийн буултын жинг, тухайн онгоцны Нислэг ашиглалтын зааварт заасан буултын жингээс хэтрүүлж болохгүй.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь, төлөвлөсөн цагт нисэн очих болон нөөц аэродромд буулт үйлдэх үеийн онгоцны буултын жинг тооцоолохдоо, зурвасны босгоноос дээш 15м /50 фут/ өндөрт байрлах цэгээс буулт үйлдэх боломжит нийт зайн 85% дотор онгоц бүрэн зогсоно гэж үзнэ.

(в) Буултын жинг энэ зүйлийн (б)-гийн дагуу тооцоолохдоо дараах зүйлийг тооцсон байна:

- 1/ аэродромын өргөгдсөн өндөр (aerodrome elevation);
- 2/ тухайн аэродромын гадна агаарын хэм;
- 3/ ХБЗ-ны гадаргуугийн төрөл, нөхцөл байдал;
- 4/ тухайн ХБЗ-ны буулт үйлдэх чиглэл дэх налуу;
- 5/ эсэргүүцэх салхины векторын 50%-иас ихгүй, эсхүл арын салхины векторын 150 %- иас багагүй байх.

(г) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (б), (в)-д заасны дагуу буулт үйлдэх онгоцыг нислэгт гаргахдаа, дараах зүйлийг тооцсоны үндсэн дээр боломжит ХБЗ-д буулт үйлдэнэ гэж тооцоолно:

- 1/ цаг агаарын урьдчилсан байдал;
- 2/ хүрээлэн байгаа газар нутаг;
- 3/ ойртолт, буултын тоноглолууд;
- 4/ ойртолтоос хоёрдугаар тойрогт гарах нислэгийн зам дахь саадууд.

(д) Гэрчилгээ эзэмшигч нь, нисэн очих (эцсийн) аэродромын хувьд энэ зүйлийн (г) заалтыг мөрдөх боломжгүй тохиолдолд нөөц аэродром нь энэ зүйлийн (а), (б) ба (в)-д нийцэж байвал онгоцыг нислэгт гаргаж болно.

135.173. Буултын зай - нойтон ба бохирдсон зурвас

(а) Гэрчилгээ эзэмшигч нь нислэг үйлдэж байгаа онгоц бүрийн хувьд дараах зүйлийг бататгана:

- 1/ цаг агаарын тухайн үеийн мэдээ, эсхүл урьдчилсан мэдээнд, онгоц нисэн очих үед ХБЗ нойтон байх магадлалтай гэж заасан бол, буултын боломжит зай нь 135.185.-д шаардсан буултын зайны 115%-иас багагүй байхыг;
- 2/ цаг агаарын тухайн үеийн мэдээ, эсхүл урьдчилсан мэдээнд, онгоц нисэн очих үед ХБЗ бохирдсон байх магадлалтай гэж заасан бол, буултын боломжит зай нь:
 - 2.1 энэ хэсгийн 1/-д шаардсан буултын зайнаас багагүй байхыг, эсхүл
 - 2.2 буултын зай нь бохирдсон зурваст буух зайн өгөгдөхүүнүүдээр тодорхойлогдсон байхыг.

(б) Өгөгдөхүүнүүд нь нойтон зурвас дээрх буултын зайг богинохон тодорхойлж болох ба энэ тохиолдолд нойтон зурвас дээрх буултын зай нь энэ зүйлийн (а)-гийн 1/-д зааснаас богино зайд байна.

135.175. Огцом ойртолт ба богино зайд буулт үйлдэх арга

(а) Гэрчилгээ эзэмшигч нь, дараах нөхцөлд ойртолтын хазайлтын 4.5° болон түүнээс илүү өнцгийг ашиглан, 10.5-15м /35-50 фут/-ийн хоорондох тэгшлэх өндөр (screen height)-г огцом ойртолтын журам /steep approach procedures/-ыг гүйцэтгэж болно:

- 1/ огцом ойртолтын үе дэх онцгой нөхцөл байдлыг багтаасан журмууд, бусад хязгаарлалтууд, ойртолтын зөвшөөрөгдсөн хамгийн их хазайлтын өнцөг зэрэг огцом ойртолтын шалгуурыг ашиглах үеийн талбайн уртын өөрчлөлтүүд нь тухайн онгоцны Нислэг ашиглалтын зааварт тусгагдсан;

- 2/ ХНД-ээр үйлдэх нислэгийн хувьд, ил харааны ойртолтын хазайлтыг дохиолох системийг багтаасан ойртолтын үеийн хазайлтыг заагч систем нь огцом ойртолт үйлдэх аэродромын хувьд боломжтой;
- 3/ ХНД-ээр үйлдэх нислэгийн хувьд цаг агаарын хязгаарлалт нь огцом ойртолт үйлдэх ХБЗ бүрд тодорхойлогдож, зөвшөөрөгдсөн;
- 4/ ХНД-ээр үйлдэх нислэгийн хувьд дараах зүйлийг анхаарсан байна:
 - 4.1. саадууд;
 - 4.2. буух ойртолтын глиссадын дохиоллын маяг болон ил харааны туслах төхөөрөмж, микродолгионы буултын систем (MLS), сансрын навигацийн байрлал тодорхойлох систем (GPS), хэрэглэлээр буулт үйлдэх систем (ILS), курсын радиомаяк (LLZ), хэт өндөр давтамжийн олон чиглэлт дамжуулагч станц (VOR), чиглүүлэх радио нэвтрүүлэгч (NDB) зэрэг ХБЗ-ны заавар;
 - 4.3. шийдвэр гаргах харьцангуй өндөр ба шийдвэр гаргах хамгийн бага өндөрт шаардагдах ил харааны лавлах хэрэгсэл;
 - 4.4. бүхээгт хэрэглэгдэх тоноглол;
 - 4.5. нисэгчийн бэлтгэл ба тусгай аэродромын талаарх мэдлэг;
 - 4.6. онгоцны нислэг ашиглалтын зааварт тусгагдсан хязгаарлалт ба журмууд;
 - 4.7. ойртолтоос хоёрдугаар тойрогт гарах нөхцөлүүд.

135.177. FAR Part 23 commuter category ба SFAR41

(а) АНУ-ын иргэний нисэхийн стандарт FAR Part 23 commuter category SFAR41-ийн онгоцыг нислэгийн үйл ажиллагаандаа ашигладаг гэрчилгээ эзэмшигчийн хувьд энэ дүрмийн 135.179. ба 135.185-р зүйлүүд хүчин төгөлдөр байна.

135.179. Хөөрөлтийн зай

(а) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үйл ажиллагаандаа ашиглах онгоцны хөөрөлтийн жинг тухайн онгоцны Нислэг ашиглалтын зааварт тусгагдсан хөөрөлтийн хамгийн их жингээс хэтрүүлж болохгүй.

(б) Энэ зүйлийн (а)-гийн шаардлагыг хангах үүднээс гэрчилгээ эзэмшигч, эрсдэлтэй хөдөлгүүр V_{ef} хурдны үед татгалзсан гэж үзэн V_1 хурдыг ашиглан хөөрөлтийн хамгийн их жинг тооцоолохдоо дараах зүйлийг бататгана:

- 1/ хөөрөлтийг зогсооход шаардагдах зай нь хөөрөлтийг зогсоох боломжит зайнаас ихгүйг;
- 2/ хөөрөлт үйлдэхэд шаардагдах зай нь хөөрөлтийн боломжит зайнаас ихгүйг;
- 3/ хөөрөлтийн боломжит зайн саадгүй байх аливаа хэсэг нь хөөрөлт үйлдэх гүйлтийн боломжит зайн хагасаас ихгүйг;
- 4/ хөөрөлт үйлдэх гүйлтийн шаардлагатай зай нь хөөрөлтийг зогсоох ба үргэлжлүүлэх, шийдвэр гаргах V_1 хурдыг ашиглан тооцсон хөөрөлт үйлдэх гүйлтийн боломжит зайнаас ихгүйг.

(в) Гэрчилгээ эзэмшигч нь, хөөрөлтийн хамгийн их жинг энэ зүйлийн (б)-гийн дагуу тооцоолохдоо дараах зүйлийг харгалзана:

- 1/ аэродромын өргөгдсөн өндөр (aerodrome elevation);
- 2/ агаарын даралт нь Стандарт агаарын даралтаас 1%-иас дээш өөрчлөлттэй тохиолдолд тухайн аэродромын даралтын өндөр;
- 3/ тухайн аэродром орчмын гадна агаарын хэм;
- 4/ тухайн ХБЗ-ны гадаргуугийн төрөл ба нөхцөл байдал;
- 5/ хөөрөлтийн чиглэл дэх ХБЗ-ны налуу;

- 6/ цаг уурын мэдээнд өгөгдсөн эсэргүүцэх салхины векторын 50%-иас ихгүй, эсхүл арын салхины векторын 150%-иас багагүй байна.

135.181. Хөөрөлтийн үеийн нислэгийн зурвас ба гаралт /SID/

(а) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа онгоц бүрийн хувьд эрсдэлтэй хөдөлгүүр татгалзсан гэж үзэх үед хөөрөлт үйлдэх нислэгийн зурвасны дагуу босоо зайд аливаа саадгүйг бататгана:

- 1/ онгоц хөөрөлтөнд 15° -аас ихгүй өнцгөөр эргэлт /bank/ үйлдэхээр бол 10.5 метр /35 фут/ -ээс дээш өндөрт;
- 2/ онгоц хөөрөлтөнд 15° -аас их өнцгөөр эргэлт /bank/ үйлдэхээр бол 15 метр / 50 фут/ -ээс дээш өндөрт.

(б) Энэ зүйлийн (а)-д хамааралтайгаар, нислэгийн замын хажуугаас аливаа саад хүртэлх зай нь дараах зайнаас бага бол саадыг хөөрөлтийн зурвасанд байна гэж үзнэ:

- 1/ нислэгийн чиглэлийг 15° -аас ихээр өөрчлөх шаардлагагүй тохиолдолд:
 - 1.1 хөөрөлт үйлдэн өндөр авах чиглэлд хөндлөн саад хүртэл $45\text{м} + 0.10D$ зайд буюу 600м хүртэл, эсхүл онгоц ил харааны буюу радио навигацийн нислэгийн журмаар нисэж байгаа бол 300м хүртэл;
 - 1.2 өдрийн цагт VMC /ил хараагаар нислэг үйлдэх цаг агаарын нөхцөл/-гээр үйлдэх нислэгийн хувьд хөөрөлт үйлдэн өндөр авах чиглэлд хөндлөн саад хүртэл $30\text{ м} + 0.10D$ зайд буюу 600м хүртэл, эсхүл онгоц ил харааны буюу радио навигацийн нислэгийн журмаар нисэж байгаа бол 300м хүртэл.
- 2/ нислэгийн чиглэлийг 15° -аас ихээр өөрчлөх шаардлагатай тохиолдолд:
 - 2.1 хөөрөлт үйлдэн өндөр авах чиглэлд хөндлөн саад хүртэл $45\text{м} + 0.10D$ зайд буюу 900м хүртэл, эсхүл онгоц ил харааны буюу радио навигацийн нислэгийн журмыг мөрддөг бол 600м хүртэл;
 - 2.2 өдрийн цагт VMC-гээр үйлдэх нислэгийн хувьд хөөрөлт үйлдэн өндөр авах чиглэлд хөндлөн саад хүртэл $30\text{м} + 0.10D$ зайд буюу 600м хүртэл, эсхүл онгоц ил харааны буюу радио навигацийн нислэгийн журмаар нисэж байгаа бол 300м хүртэл. (*D-хөөрөлтийн боломжит зайн төгсгөл /онгоц хөөрч өндөр аван 15м-т хүрэх цэг/-өөс саад хүртэлх хэвтээ зайн хэмжээ*).

(в) Гэрчилгээ эзэмшигч нь, хөөрөлтийн үеийн нислэгийн замыг энэ зүйлийн (а)-гийн дагуу тооцоолохдоо дараах зүйлийг бататгана:

- 1/ дараах нөхцөл байдлыг тооцсон гэдгийг:
 - 1.1 хөөрөх гүйлт эхлүүлэхээс өмнөх хөөрөлтийн жин;
 - 1.2 аэродромын өргөгдсөн өндөр (aerodrome elevation);
 - 1.3 агаарын даралт нь Стандарт даралтаас 1%-иас дээш өөрчлөлттэй үеийн аэродромын даралтын өндөр;
 - 1.4 аэродром орчмын агаарын температур;
 - 1.5 цаг агаарын мэдээнд өгөгдсөн эсэргүүцэх салхины векторын 50%- иас ихгүй, эсхүл арын салхины 150%-иас багагүй байх.
- 2/ хөөрөлт үйлдэж байгаа зурваснаас дээш 15м /50 фут/-ийн өндөрт хүртэл нислэгийн чиглэлийг өөрчлөхгүй байхыг;
- 3/ ИНЕГ-аас өөрөөр зөвшөөрөөгүй бол:
 - 3.1 хөөрөлт үйлдэж байгаа зурваснаас дээш 15м /50 фут/-ийн өндөрт хүртэл 15° -аас их эргэлт үйлдэхгүйг;
 - 3.2 хөөрөлт үйлдэж байгаа зурваснаас дээш 120м /400 фут/-ийн өндөрт хүртэл 20° -аас их эргэлт үйлдэхгүйг;

3.3 хөөрөлт үйлдэж байгаа зурваснаас дээш 120м /400 фут/-ээс дээш өндөрт 25°-аас их эргэлт үйлдэхгүйг;

4/ дараах зүйлүүдийг мөрдөхийг:

4.1 эргэлт үйлдэх нь нислэгийн чиглэл болон нислэгийн хурдад нөлөөлөхийг;

4.2 нислэгийн хурдыг ихэсгэснээс зай нэмэгдэхийг;

4.3 өндөр авалтын градиентын алдагдал болон хурдны уналт (stall)-ын хязгаарыг барихыг.

135.183. Буултын зай - хуурай зурвас

(а) Гэрчилгээ эзэмшигч нь, нислэгт ашиглаж буй онгоц бүрийн хувьд, төлөвлөсөн цагт буух үеийн онгоцны буултын жинг тухайн онгоцнуудын Нислэг ашиглалтын зааварт заасан буултын жингээс хэтрүүлж болохгүй.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь ашиглаж буй онгоц бүрийн хувьд, төлөвлөсөн цагт нисэн очих аэродром болон аливаа нөөц аэродромд буулт үйлдэх онгоцны буултын жин нь зурвасны босгоноос дээш 15м /50 фут/-т байрлах цэгээс буулт үйлдэх боломжит зай /LDA/-н 70% дотор онгоц бүрэн зогсоно гэж тооцоолсон байна.

(в) Буултын жинг энэ зүйлийн (б)-гийн дагуу тооцоолохдоо дараах зүйлийг харгалзана:

1/ аэродромын өргөгдсөн өндөр (aerodrome elevation);

2/ тухайн аэродром дахь гадна агаарын хэм;

3/ ХБЗ-ны гадаргуун төрөл, нөхцөл байдал;

4/ тухайн ХБЗ-ны буулт үйлдэх чиглэл дэх налуу;

5/ цаг агаарын мэдээнд өгөгдсөн эсэргүүцэх салхины векторын 50%-иас ихгүй, эсхүл арын салхины векторын 150%-иас багагүй байх.

(г) Гэрчилгээ эзэмшигч энэ зүйлийн (б), (в)-д заасны дагуу буултын тооцоо хийх онгоцыг нислэгт гаргахдаа, тухайн онгоц дараах нөхцөлийг тооцсон хамгийн боломжтой ХБЗ-д буулт үйлдэнэ гэж үзнэ:

1/ цаг агаарын урьдчилсан байдал;

2/ хүрээлэн байгаа газар нутаг;

3/ ойртолт, буултын тоноглолууд;

4/ ойртолтоос хоёрдугаар тойрогт гарах нислэгийн зам дахь саадууд.

(д) Гэрчилгээ эзэмшигч нь нисэн очих аэродромын хувьд энэ зүйлийн (г)-д заасныг мөрдөх боломжгүй тохиолдолд, хэрэв нөөц аэродром нь энэ зүйлийн (а), (б) ба (в)-д нийцэж байгаа бол онгоцыг нислэгт гаргаж болно.

135.185. Буултын зай - нойтон ба бохирдсон зурвас

(а) Цаг агаарын бодит, эсхүл урьдчилсан мэдээнд, онгоц нисэн очих үед ХБЗ нойтон, эсхүл бохирдсон байх магадлалтай гэж заасан бол нислэгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа онгоц бүрийн хувьд буултын боломжит зай 135.135-д шаардсан буултын зайн 115%-иас багагүй байна гэдгийг Гэрчилгээ эзэмшигч бататгана.

Д БҮЛЭГ. ЖИН БА ТӨВЛӨРӨЛТ

135.201. Зорчигч, ачаа болон тээшний жин

(а) Гэрчилгээ эзэмшигч нь тээвэрлэх зорчигчдын болон тэдний гар тээш, ачааны бодит жинг тогтоосон байна.

(б) Зорчигчдын жинг дараах байдлаар тогтооно:

- 1/ зорчигчдын бодит жингээр, эсхүл
- 2/ зорчигчдын стандарт жингээр:
 - 2.1 насанд хүрсэн том хүн- 77 кг;
 - 2.2 4-14 насны хүүхэд- 46 кг;
 - 2.3 4-өөс доош насны хүүхэд -15 кг.
- 3/ гэрчилгээ эзэмшигчийн зааварт тусгагдсан стандарт жингээр.

135.203. Агаарын хөлгийн ачааллын хязгаарлалтууд

(а) Гэрчилгээ эзэмшигч нь онгоцны жин төвлөрөлтийг тооцоолох хуудаастай байна:

- 1/ агаарын хөлгийн Нислэг ашиглалтын зааварт, эсхүл жин ба төвлөрөлттэй хамааралтай бусад зөвшөөрөгдсөн бичиг баримтад заасан хязгаарлалтуудыг дагаж мөрдөнө;
- 2/ агаарын хөлгийн түлшгүй үеийн, мөн хөөрөлт, буултын ба нислэгийн үеийн жинг зөвшөөрөгдсөн хамгийн их жингээс хэтрүүлэхгүй;
- 3/ хөөрөлтийн өмнөх агаарын хөлгийн хүндийн төвийг энэ зүйлийн 1/-д заагдсан хязгаарлалтад байлгах ба эдгээр хязгаарлалтуудыг нислэгийн турш баримтална.

Е БҮЛЭГ. ХЭРЭГЛЭЛ БОЛОН ТОНОГЛОЛ

135.251. Ерөнхий зүйл

(а) Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангаагүй тохиолдолд агаарын тээврийн үйл ажиллагааг эхлүүлэхгүй:

- 1/ агаарын хөлөг нь :
 - 1.1 энэ бүлэг болон ИНД-91-д шаардсан тухайн төрөл, маягийн хэрэглэл тоноглолуудтай байх;
 - 1.2 холбоо, навигацийн систем, тоноглолууд нь аливаа дутагдлын үед бие биенээ орлон найдвартай ажиллагааг хангадаг байх.
- 2/ тухайн агаарын хөлөгт суурилагдсан хэрэглэл, тоноглолууд нь дараах НТЧ-ын загварын стандартууд болон тодорхойлолтыг дагаж мөрдсөн байх:
 - 2.1 энэ дүрмийн Хавсралт Б, эсхүл
 - 2.2 ИНД-21-ийн Хавсралт В, эсхүл
 - 2.3 ИНД-26, эсхүл
 - 2.4 ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрсөн нэмэлт тодорхойлолт болон стандартууд.
- 3/ хэрэглэл тоноглолууд нь тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн заавар болон ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн бусад заавар, зааварчилгын дагуу суурилагдсан байх;
- 4/ ИНД-91-ийн дагуу батлагдсан MEL-д зааснаас бусад, тухайн агаарын хөлөгт суурилагдсан хэрэглэл тоноглолууд нь ажиллагаатай байх.

135.253. Суудлын даруулга

(а) Гэрчилгээ эзэмшигчийн нислэгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа онгоц бүрийн нисэх багийн гишүүдийн суудал нь мөрөвчит даруулга бүсээр тоноглогдсон байна.

135.255. Нэмэлт хэрэглэлүүд

(а) Гэрчилгээ эзэмшигчийн агаарын хөлөг бүр дараах хэрэглэлүүдээр тоноглогдсон байна:

- 1/ ИНД-21-д заасан НТЧ-ын загварын стандартын шаардлага хангасан хөдөлгүүрийн хэрэглэлүүд;
- 2/ сэнсний алганы өнцгийн өөрчлөлтөөр ухрах хүч өгөх сэнсний хувьд сэнс тулгуур дээр байх өнцөг /beta хязгаарт/, эсхүл эсрэг татах хүч үүсгэх өнцөг (reverse pitch) дээр байгааг заагч хэрэглэл буюу сэнсний алхам заагч.

135.257. Шөнийн нислэг

(а) Гэрчилгээ эзэмшигчийн шөнийн нислэг үйлдэж байгаа агаарын хөлгүүд нь дараах тоноглолуудаар тоноглогдсон байна:

- 1/ буултын гэрэл;
- 2/ зорчигчдын тасалгааны гэрэл.

135.259. Хэрэглэлийн нислэгийн дүрэм

(а) Гэрчилгээ эзэмшигчийн, ХНД-ийн дагуу нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг нь дараах тоноглолоор тоноглогдсон байна:

- 1/ бие биенээсээ үл хамаарах, дараах нэмэлт заагч хэрэглэл:
 - 1.1 чийг, эсхүл мөстөлтийн улмаас хэвийн ажиллагаа нь алдагдахаас хамгаалагдсан, км/ц (knot)-аар хэмжигдэх хурдны хэрэглэл;
 - 1.2 өндрийг /даралтаар/ метр (фут)-ээр хэмжих хэрэглэл.
- 2/ нисгэгчийн бүхээг дэх хэрэглэлүүдийн гэрэлтүүлгэд зориулсан нөөц чийдэн;
- 3/ нөөц гал хамгаалагч.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь, энэ зүйлийн (а)-гийн 1/-гийн 1.1-ээс үл хамааран тусдаа тэжээлийн үүсгүүртэй нэмэлт авиагоризонт (attitude indicator)-ыг суурилуулж болно.

(в) Дээрх тоноглолуудаар тоноглогдоогүй агаарын хөлгийг ХНД-ээр нислэг үйлдэхийг хориглоно.

135.261. Авран хамгаалах тоноглол

(а) ИНД-91-д заасныг үл харгалзан, Гэрчилгээ эзэмшигчийн агаарын хөлөг бүрт эмнэлгийн анхан шатны тусламжийн хэрэгслүүдийг байрлуулж, нисэх бүрэлдэхүүн нь анхан шатны тусламж үзүүлэх сургалтад хамрагдсан байна.

(б) ИНД-91-ийн холбогдох шаардлагуудад нийцсэн авран хамгаалах тоноглолоор тоноглогдсон байна.

135.263. Бүхээгийн дуу чимээ бичигч

(а) Гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд, нислэгийн үйл ажиллагаандаа ашиглах нисдэг тэргийг бүхээгийн дуу чимээ бичигчээр тоногдсон байна:

- 1/ тухайн нисдэг тэрэгний Нислэг ашиглалтын зааварт хоёр буюу түүнээс дээш тооны нисэх багийн гишүүнтэй байхыг шаардсан бол;
- 2/ тухайн нисдэг тэрэг нь нисэх багийн гишүүдийн суудлаас гадна 10 буюу түүнээс дээш тооны суудалтай бол.

135.265. Нислэгийн өгөгдөхүүн бичигч

(а) 5700 – кг-аас доош хөөрөлтийн жинтэй турбинт олон хөдөлгүүртэй онгоц нь Type II A, нисдэг тэрэг нь Type IV эсхүл Type V маягийн нислэгийн өгөгдөхүүн бичигчээр тоноглогдсон байна.

(б) энэ зүйлийн (а)-д заагдсан нислэгийн өгөгдөхүүн бичигч нь Хавсралт А-гийн А.2-т заасан шаардлагыг хангасан байна.

135.267. Нэмэлт авиагоризонт

(а) Гэрчилгээ эзэмшигчийн нислэгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа тийрэлтэт, эсхүл сэнст тийрэлтэт хөдөлгүүр бүхий агаарын хөлөг бүр нь гуравдагч нэмэлт авиагоризонтоор тоноглогдсон байна.

135.269. Нислэгийн бичигч төхөөрөмжүүд /FDR,CVR/-ийн ажиллагаа болон бичлэгийг хадгалах

(а) Нислэгийн үед бичлэгийн төхөөрөмжүүдийг салгахыг хориглоно.

(б) Агаарын хөлөг осол, зөрчилд өртсөн тохиолдолд Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн бичигч төхөөрөмжүүдийн мэдээллийг хадгалах зорилгоор тэдгээрийг салгаж, бичигдсэн мэдээллийг 60 хоног хүртэл, хэрэв эрх бүхий байгууллага шаардсан бол илүү урт хугацаагаар хадгална.

(в) Нислэгийн бичигч төхөөрөмжийг дахин идэвхжүүлэхээс өмнө Чикагогийн конвенцийн Хавсралт 13-ын Attachment D /Нислэгийн бичигч төхөөрөмжүүдийг унших ба дүн шинжилгээ хийх гарын авлага/-д заасан шаардлагыг хангасан байна.

Ж БҮЛЭГ. ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭ**135.301. Техник үйлчилгээ**

(а) Гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлгийн техник үйлчилгээний талаар дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ 135.303.-ийн шаардлагууд, эсхүл
- 2/ 135.303 - 135.315-ын шаардлагууд.

135.303. Агаарын хөлгийн НТЧ-ыг хариуцах

(а) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгт ашиглаж байгаа агаарын хөлгийн их бие, хөдөлгүүр, сэнс, ротор, хэрэглэл, аваарын тоноглол болон эд ангийн НТЧ-т анхдагч хариуцлагыг хүлээнэ.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, сэнс, ротор, хэрэглэл, аваарын тоноглол болон эд анги бүрд зориулсан Техник үйлчилгээний хөтөлбөртэй байна.

(в) Энэ зүйлийн (б)-д заасан Техник үйлчилгээний хөтөлбөр нь, ИНД-91-ийн Ж бүлэгт заасан стандартууд болон үйлдвэрлэгчийн Техник үйлчилгээний хөтөлбөрт тусгагдсан стандартуудаас бүрдэнэ.

(г) Гэрчилгээ эзэмшигч, эсхүл түүний техник үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа аливаа байгууллага нь холбогдох Техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу гүйцэтгэнэ.

135.305. Агаарын хөлгийн техник үйлчилгээний талаар хүлээх үүрэг

(а) Гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлөг, түүний их бие, хөдөлгүүр, сэнс, ротор, хэрэглэл, аваарын тоноглол, эд ангид хийх техник үйлчилгээг:

- 1/ ИНД-145-ын дагуу гэрчилгээжсэний үндсэн дээр, энэ дүрэм болон өөрийн үйл ажиллагааны зааврын дагуу гүйцэтгэнэ, эсхүл
- 2/ ИНД-145-ын дагуу гэрчилгээжсэн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлнэ;
- 3/ Агаарын хөлгийн ашиглалтад илэрсэн техникийн дараах гэмтэл, дутагдлын талаар ИНЕГ-ын НТЧ-ын хэлтэст мэдээлнэ:
 - 3.1 нислэгийн үед гал гарсны улмаас гал эсэргүүцэх систем ажилласан;
 - 3.2 нислэгийн үед агаарын хөлгийн гал эсэргүүцэх систем хуурамчаар ажилласан;
 - 3.3 нислэгийн үед агаарын хөлгийн гаралтын системд эвдрэл үүсэж хөдөлгүүр болон эд анги, бүтцэд гэмтэл учруулсан;
 - 3.4 нислэгийн үед агаарын хөлгийн эд анги, системийн ажиллагаанаас шалтгаалан нисэх багийн болон зорчигчийн кабинд утаа, уур манан, хортой хий бий болсон;
 - 3.5 нислэгийн үед хөдөлгүүрийг унтраасан, эсхүл өөрөө унтарсан;
 - 3.6 нислэгийн үед сэнсний флюгер ба хэт эргэлтийг удирдах системд гэмтэл гарсан;
 - 3.7 түлшний систем болон түлш агаарт цацах системд гэмтэл гарсан, түлш асгарсан;
 - 3.8 нислэгийн үед хөл анги өөрөө буух буюу хураагдсан, дугуйны створка хаалга өөрөө нээгдэх буюу хаагдсан;
 - 3.9 агаарын хөлөг газарт явгалах үед дугуйны удирдлага, тормоз алдагдсан;
 - 3.10 агаарын хөлгийн бүтцэд үндсэн засвар хийх шаардлагатай болсон;
 - 3.11 агаарын хөлгийн бүтцэд үйлдвэрлэгчийн зөвшөөрсөн засварлах хэмжээнээс илүү хэмжээтэй цууралт, зэврэлт, деформаци үүссэн;
 - 3.12 агаарын хөлгийн систем, тоноглолд илэрсэн дутагдлын улмаас нислэгийн онцгой нөхцөл байдал үүссэн;
 - 3.13 техникийн шалтгаанаас агаарын хөлгийн нислэгийн маршрут өөрчлөгдсөн, нислэгийг зогсоосон;
 - 3.14 агаарын хөлгийн хөдөлгүүрийг хугацаанаас нь өмнө буулгах шаардлагатай болсон;
 - 3.15 нислэгийн үед агаарын хөлөгт аюултай чичиргээ үүссэн;
 - 3.16 нислэгийн үед авиагоризонт, хурд, өндрийн болон навигацийн хэрэглэл татгалзсан.

135.307. Сургалтын болон мэдээллийн хөтөлбөр

(а) Техник үйлчилгээгээ бие даан гүйцэтгэж байгаа гэрчилгээ эзэмшигч, эсхүл түүний техник үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа аливаа этгээд нь техник үйлчилгээнээс гаргах эрх бүхий хүмүүст зориулсан сургалтын болон мэдээллийн хөтөлбөртэй байх ба энэхүү хөтөлбөр нь дараах зүйлийг бататгана:

- 1/ ажлын аргачлал, журмуудын талаар болон шинээр ашиглаж байгаа тоноглолуудын талаарх мэдээллээр бүрэн хангагдахыг;
- 2/ олгогдсон үнэмлэх гэрчилгээний дагуу ажил үүрэг гүйцэтгэх чадвартайг.

135.309. Техник үйлчилгээг баталгаажуулах ажилтанд тавигдах шаардлага

(а) Гэрчилгээ эзэмшигчийн техник үйлчилгээг баталгаажуулах (техник үйлчилгээнээс гаргах) ажилтан нь зохих сургалтад хамрагдсан, дадлага туршлагатай, техник үйлчилгээнээс гаргах эрхтэй байна.

135.311. ТҮ-нд хяналт тавих ажилтанд тавигдах шаардлага

(а) ТҮ-гээ бие даан гүйцэтгэж байгаа Гэрчилгээ эзэмшигч, эсхүл түүний ТҮ-г гэрээгээр гүйцэтгэж байгаа байгууллагын ТҮ-нд хяналт тавих, эсхүл засвар үйлчилгээний шийдвэр гаргах ажилтанд ИНД-145-д шаардсан ТҮ-ний байгууллагын зааврын дагуу тухайн байгууллагаас эрх олгогдсон байна.

135.313. ТҮ-ний ажилтны ажлын цагийн хязгаарлалт

(а) ТҮ-гээ бие даан гүйцэтгэж байгаа Гэрчилгээ эзэмшигч, эсхүл түүний ТҮ-г гэрээгээр гүйцэтгэж байгаа аливаа этгээд ТҮ-ний ажилтны ажил, амралтын цагийн хязгаарлалтын хувьд ИНД-43-т заасан хязгаарлалтыг мөрдөнө.

135.315. Техник үйлчилгээг дүгнэх

(а) Гэрчилгээ эзэмшигч нь ТҮ-ний гүйцэтгэлийг дүгнэсэн тухай тэмдэглэл хөтлөх ба хэрэв агаарын хөлгийн ТҮ-г өмнөх 12 сарын дотор шалгаагүй бол тухайн агаарын хөлгийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлгийн ТҮ-ний гүйцэтгэлийг дүгнэх явцдаа дараах зүйлийг бататгана:

- 1/ тухайн агаарын хөлгийн Техник үйлчилгээний хөтөлбөрт заасан бүх техник үйлчилгээ хугацаандаа хийгдсэнийг;
- 2/ бүх хүчин төгөлдөр НТЧ-ын удирдамж /AD/-ууд хийгдсэнийг;
- 3/ ИНД-43-т заасан, техник үйлчилгээний бичиг баримтад хөтлөгдсөн бүх дутагдлыг гэрчилгээ эзэмшигчийн зааврын дагуу засаж залруулсан, эсхүл хойшлогдсоныг;
- 4/ Техник үйлчилгээнээс гаргах бүх ажиллагаа ИНД-43-ын дагуу хийгдсэнийг.

(в) Гэрчилгээ эзэмшигч нь ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн, Чанарын дотоод баталгаажуулалтын хөтөлбөрийн байнгын мөрдөлтөд үндэслэн техник үйлчилгээний гүйцэтгэлийг дүгнэсэн тухай тэмдэглэл үйлдэж болох ба хөтөлбөрт дараах зүйлүүд тусгагдсан байна:

- 1/ дүгнэлтийн явцад энэ зүйлийн (б)-гийн шаардлагууд хянагдсан байх талаар;
- 2/ техник үйлчилгээний гүйцэтгэлийн дүгнэлт нь агаарын хөлөг бүрийн хувьд хийгдэж баталгаажсан байх талаар.

(г) Гэрчилгээ эзэмшигч нь техник үйлчилгээний гүйцэтгэлийн дүгнэлтийн хувьд дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ дүгнэлтийг, тухайн агаарын хөлгийн маягийн хувьд дадлага туршлагатай, агаарын хөлгийн ТҮ-ний инженерийн мэргэжлийн үнэмлэхтэй эрх бүхий этгээд гүйцэтгэнэ;
- 2/ дүгнэлтийг гүйцэтгэсэн этгээд нь дараах тэмдэглэлийг хийсэн байна:

Энэхүү агаарын хөлөгт болон түүний тоног төхөөрөмжид хийгдсэн Техник үйлчилгээний гүйцэтгэлийн дүгнэлт нь тэдгээрийн НТЧ-ыг хадгалах зайлшгүй шаардлагын үүднээс, ИНБД-ийн дагуу хийгдсэн болно.

гарын үсэг _____ огноо _____

3 БҮЛЭГ. НИСЭХ БАГИЙН ГИШҮҮДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

135.351. Нисэх багийг томилох

(а) Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан этгээдийг нисэх багийн гишүүнээр томилж нислэгийн үйл ажиллагаанд оролцуулна:

- 1/ тухайн ажил үүрэгт тохирсон хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэх, зэрэглэлтэй;
- 2/ эрүүл мэндийн хүчин төгөлдөр гэрчилгээтэй;
- 3/ нисэх багийн гишүүний ажил үүрэгт тавигдах шаардлагуудыг хангасан;
- 4/ үйлдэх гэж буй нислэгийн бүх чиглэл болон аэродромын талаар зохих мэдлэгтэй.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь нислэг бүрт дараах этгээдийг томилсон байна:

- 1/ агаарын хөлгийн даргыг;
- 2/ хоёр ба түүнээс дээш тооны нисгэгч шаардлагатай бол туслах нисгэгчийг;
- 3/ гүйцэтгэх нислэгийн төрлөөс хамааран нисэх багийн бусад гишүүдийг.

135.353. Агаарын хөлгийн даргын дадлага туршлагад тавигдах шаардлагууд

(а) Агаарын хөлгийн даргаар томилогдох этгээд нь тухайн загвар, маягийн агаарын хөлгийн хувьд дараах дадлага туршлагатай байна:

- 1/ нэг хөдөлгүүрт агаарын хөлгөөр 5 цагийн нислэг, 5 удаагийн хөөрөлт буулт үйлдсэн;
- 2/ поршинт, эсхүл турбинт олон хөдөлгүүрт агаарын хөлгөөр 10 цагийн нислэг, 8 удаагийн хөөрөлт буулт үйлдсэн;
- 3/ турбинт тийрэлтэт, эсхүл сэнст турбинт хөдөлгүүрт онгоцоор 15 цагийн нислэг, 10 удаагийн хөөрөлт буулт үйлдсэн.

(б) Энэ зүйлийн (а)-д шаардсан дадлага туршлагыг дараах байдлаар эзэмшсэн байна:

- 1/ зөвхөн нислэгийн үйл ажиллагааны явцад эзэмшсэн байх бөгөөд нислэгийн дадлагажуур дээр гүйцэтгэсэн нислэгийн цаг, хөөрөлт буултыг тооцохгүй;
- 2/ гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаанд урьд нь ашиглагдаж байгаагүй агаарын хөлгийн хувьд, тухайн маягийн агаарын хөлөг дээр гүйцэтгэсэн шалгах нислэг, эсхүл техникийн нислэгийн явцад эзэмшсэн байж болно;
- 3/ эрх бүхий багш нисгэгчийн хяналтад агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх явцад эзэмшсэн байж болно.

135.355. Хамгийн цөөн нисэх баг- ХНД-ийн дагуу үйлдэх нислэг

(а) Гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд нэг нисгэгчтэй агаарын хөлгөөр ХНД-ийн дагуу нислэг үйлдэхгүй:

- 1/ тухайн агаарын хөлгийн Нислэг ашиглалтын зааварт нэг нисгэгчтэйгээр нислэг үйлдэхийг зөвшөөрөөгүй бол;
- 2/ тухайн агаарын хөлөг автопилотгүй, эсхүл онгоцны хөндлөн ба дагуу тэнхлэгийн дагуу нислэгийн маневруудыг гүйцэтгэх болон өндрийг тогтмол бариулах автомат удирдлагагүй бол;
- 3/ товчлууур нь агаарын хөлгийн даргын жолоон дээр суурилагдсан микрофон бүхий чихэвчгүй бол;
- 4/ агаарын хөлгийн дарга энэ дүрмийн бусад шаардлагуудыг хангаагүй бол.

И БҮЛЭГ. СУРГАЛТ ДАДЛАГА

135.401. Ерөнхий зүйл

(а) Гэрчилгээ эзэмшигч нь, нисэх багийн гишүүдийн ур чадварыг хадгалах, дээшлүүлэхэд чиглэсэн Сургалтын хөтөлбөртэй байна.

(б) Гэрчилгээ эзэмшигчийн нисэх багийн гишүүд нь энэ зүйлийн (а)-д заасан Сургалтын хөтөлбөрийн дагуу сургалт, дадлагад хамрагдсан байна.

(в) Гэрчилгээ эзэмшигч нь өөрийн Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих үүрэгтэй.

(г) Гэрчилгээ эзэмшигч нь Сургалтын хөтөлбөрөө:

- 1/ өөрөө бие даан хэрэгжүүлж болно, эсхүл
- 2/ ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн сургалт, дадлагын байгууллагатай гэрээ байгуулж болно, эсхүл
- 3/ ИНД-141-ийн стандарт шаардлагыг хангасан гадаадын сургалтын байгууллагатай гэрээ байгуулна.

(д) ИНЕГ-аас баталсан гэрчилгээ эзэмшигчийн нисэх багийн гишүүдийн сургалтын хөтөлбөрийн дагуух сургалтанд нисгэгч өөрийн биеэр сургалт, дадлагад хамрагдсан байна.

135.403. Сургалт дадлагын бүртгэл тэмдэглэл

(а) Гэрчилгээ эзэмшигч нь, нисэх багийн гишүүдийн хийсэн дадлага, сургалтыг нарийвчлан бичсэн бүртгэл тэмдэглэлтэй байна.

135.405. Нисэх багийн гишүүдийн анхан шатны сургалт

(а) Агаарын хөлгийн нисэх багийн анхан шатны сургалтыг дараах байдлаар хийсэн байна:

- 1/ төлөвлөгөөний дагуу;
- 2/ сургалтын хөтөлбөрийн дагуу:
 - 2.1. онгоцны маягийн хувьд болон үйлдэх гэж буй нислэгт зориулан суурилуулсан тусгай тоноглолууд дээр;
 - 2.2. үйлдэх гэж буй нислэгт ашиглах аэродромууд болон нислэгийн чиглэлүүдээр;
 - 2.3. нисэх багийн гишүүдийн томилолт, үйл ажиллагаа, үүрэг хариуцлагын талаар;
 - 2.4. нисэх багийн гишүүдэд зориулсан аврах тоноглолын байрлал, тэдгээрийн ажиллагааны талаар;
 - 2.5. хүчилтөрөгчийн тоноглолын байрлал, ашиглалтын талаар; ердийн болон аврах гарц хаалга, аваарын гулсах шат болон олсны байрлал, ашиглалтын талаар;
 - 2.6. гэрчилгээ эзэмшигчийн нислэгийн үйл ажиллагааны бодлого, журмуудын талаар.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд сургалтын хөтөлбөрийг нисэх багийн гишүүн бүрийн хувьд өөрчилж болно:

- 1/ тухайн өөрчлөлт нь нисэх багийн гишүүдийн сургалт, дадлагын бүртгэл тэмдэглэлд бичигдэх бол;
- 2/ сургалт, дадлагын бүртгэл тэмдэглэлд бичигдэх өөрчлөлт, түүний шалтгааныг гэрчилгээ эзэмшигч баталгаажуулсан бол.

135.407. Нисэх багийн гишүүдийн шилжин сургалт

(а) Нислэгийн үйл ажиллагаанд нисэх багийн гишүүнээр үүрэг гүйцэтгэж байгаа болон бэлтгэгдсэн аливаа этгээд дараах тохиолдолд шилжин сургалтад хамрагдана:

- 1/ нэг маягийн агаарын хөлгөөс өөр маягийн агаарын хөлөгт шилжих бол;
- 2/ нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн маягийн хувьд шинэ журам мөрдөх, эсхүл шинэ тоноглолууд ашиглах бол.

(б) Шилжин сургалт нь дараах зүйлд чиглэсэн байна:

- 1/ тухайн агаарын хөлгийн маягт нийцсэн журам, аюулгүй ажиллагааны болон аврах тоноглолуудын ашиглалт;
- 2/ нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн маягийн хувьд гарсан шинэ журам, эсхүл шинэ тоноглолуудыг судлах.

135.409. Давтан сургалт / Recurrent training for crew members

(а) Нисэх багийн гишүүд нь үйлдэж байгаа нислэгийн төрөл, гүйцэтгэж байгаа ажил үүрэг, агаарын хөлгийн хувьд тохирох сургалтад хамрагдаж бэлтгэгдсэн, ур чадвартай байна.

135.411. Багийн бусад гишүүдийн сургалтын хөтөлбөр

(а) Гэрчилгээ эзэмшигч нь багийн бусад гишүүдэд зориулсан Сургалтын хөтөлбөртэй байна.

(б) Багийн бусад гишүүдэд зориулсан анхан шатны, шилжин болон давтан сургалтын шаардлагууд нь дараах зүйлд нийцсэн байна:

- 1/ тухайн нислэгт зориулсан тусгай тоноглол, агаарын хөлгийн маягт;
- 2/ үйлдэх гэж буй нислэгийн чиглэлүүд болон ашиглах аэродромуудад;
- 3/ гэрчилгээ эзэмшигчийн нислэгийн үйл ажиллагааны бодлого, журмуудад.

(в) Газрын болон нислэгийн зохих зааварчилгыг шаардлагатай бол агаарын хөлөг дээр, эсхүл зөвшөөрөгдсөн нислэгийн дадлагажуур дээр өгөхөөр Сургалтын хөтөлбөрт тусгасан байна.

(г) Сургалтыг энэ дүрмийн 135.193-ын шаардлагыг хангасан багш нисгэгч удирдана.

(д) Гэрчилгээ эзэмшигч нь багийн бусад гишүүдийн мэргэшлийн талаарх бүртгэл тэмдэглэлийг үйлдэж хадгална.

135.413. Багш нисгэгчийн мэргэшлийн бэлтгэлд тавигдах шаардлага

(а) Энэ дүрмийн дагуу багийн бусад гишүүдийн сургалт, дадлагыг удирдах багш нисгэгчид дараах шаардлага тавигдана:

- 1/ энэ бүлгийн шаардлагын дагуу, агаарын хөлгийн даргаар амжилттай бэлтгэгдсэн;
- 2/ А, В, С ангиллын багш нисгэгчийн зэрэглэлтэй;
- 3/ багш нисгэгчийн хамрагдсан байвал зохих анхан шатны болон давтан сургалтыг амжилттай дүүргэсэн.

К БҮЛЭГ. БАГИЙН ГИШҮҮДИЙН УР ЧАДВАРТ ТАВИГДАХ ШААРДЛАГУУД**135.451. Ерөнхий зүйл**

(а) Гэрчилгээ эзэмшигч нь энэ дүрмийн шаардлагын дагуу, нисэх баг болон багийн бусад гишүүдийн нислэгийн ур чадварыг үнэлэх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь:

- 1/ нислэгийн ур чадварыг үнэлэх хөтөлбөрийг бие даан хэрэгжүүлж болно, эсхүл
- 2/ ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно, эсхүл
- 3/ ИНД-141-ийн стандартыг хангасан гадаадын байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

135.453. Шалгах нисгэгчийн бэлтгэл, ур чадвар

(а) Энэ зүйлийн (б)-г үл харгалзан, ур чадварыг үнэлэх хөтөлбөрийн дагуу нисгэгчийн нислэгийн ур чадварыг шалгах аливаа этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж буй агаарын хөлгийн маягийн хувьд зэрэглэлтэй;
- 2/ гэрчилгээ эзэмшигчийн явуулж буй нислэгийн үйл ажиллагааны төрлүүдийн талаар мэдлэгтэй;
- 3/ шалгах нисгэгчийн зэрэглэлтэй;
- 4/ шалгах нисгэгчийн хамрагдсан байвал зохих анхан шатны болон давтан сургалтуудыг амжилттай дүүргэсэн.

(б) Энэ зүйлийн (а)-д дурьдсан нислэгийн ур чадварыг дадлагажуур дээр шалгаж байгаа шалгах нисгэгч нь дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ энэ дүрмийн дагуу үйлдэх нислэгийн төрөлд агаарын хөлгийн даргаар ур чадварын шалгалтыг амжилттай өгсөн;
- 2/ шалгах нисгэгчийн зэрэглэлтэй;
- 3/ шалгах нисгэгчийн хамрагдсан байвал зохих анхан шатны болон давтан сургалтуудыг амжилттай дүүргэсэн.

135.455. Нисэх багийн гишүүдийн ур чадварыг шалгах

(а) Гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлийг бататгана:

- 1/ агаарын хөлгийн даргын хувьд, өмнөх 12 сарын дотор шалгах нисгэгчийн хяналтан дор аэродромын болон чиглэлийн нислэгийн шалгалтуудыг амжилттай өгсөн байх ба үүнд:
 - 1.1 нислэгийн нэг бүтэн үед нислэг үйлдэх ба нислэгийн үйл ажиллагаанд ашиглагдах аэродромуудад нэгээс дээш буулт үйлдэх нислэгийн шалгалт;
 - 1.2 энэ дүрмийн дагуу гүйцэтгэх нислэгийн үйл ажиллагаанд агаарын хөлгийн даргын үүрэг хариуцлагыг "хангалттай" гүйцэтгэж чадахаа харуулсан.
- 2/ ИХНД-ээр нислэг үйлдэж байгаа нисгэгчийн хувьд, өмнөх 12 сарын дотор, онцгой нөхцөл байдлын үед мөрдөх журам болон бусад журмыг багтаасан ур чадварын шалгалтыг шалгах нисгэгчийн хяналтан дор, тухайн нисгэгч нислэгийн үйл

- ажиллагаанд ашиглаж байсан агаарын хөлөгтэй ижил төстэй агаарын хөлөг дээр амжилттай өгсөн байх;
- 3/ ХНД-ээр нислэг үйлдэж байгаа нисгэгчийн хувьд, өмнөх 6 сарын дотор шалгах нисгэгчийн хяналтан дор дараах шалгалтуудыг амжилттай өгсөн байх:
- 3.1 онцгой нөхцөл байдлын үед тухайн агаарын хөлөгт суурилагдсан тоног төхөөрөмжтэй харьцаж ажиллах журам болон бусад журмууд, тухайн нисгэгчийн үйлдэх нислэгийн үйл ажиллагааны төрлүүдээр;
 - 3.2 хөөрөлтийн нийт жин 5700 кг-с доош жинтэй болон хоёр хөдөлгүүртэй 12 хүртлэх хүний суудалтай агаарын хөлгийн төрөл тус бүр дээр 6 сар тутамд нэг удаа;
- 4/ нисгэгч бүрийн хувьд, өмнөх 12 сарын дотор дараах онолын шалгалтуудыг бичгээр, эсхүл амаар өгсөн байх:
- 4.1 Иргэний нисэхийн хууль, дүрэм, Гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны тодорхойлолт болон зааврын талаарх мэдлэг;
 - 4.2 тухайн нисгэгчийн нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн системүүд, нислэг-техникийн өгөгдөхүүнүүд болон нислэгийн журмууд, хүлээн зөвшөөрөгдсөн Нислэг ашиглалтын зааврын талаарх мэдлэг;
 - 4.3 навигаци, НХУ, цаг уурын мэдлэг;
 - 4.4 тухайн нислэгийн төрөлд хамааралтай тусгай нислэгийн үйл ажиллагааны талаарх мэдлэг;
 - 4.5 шинэ тоноглол, журам, арга ажиллагаа;
 - 4.6 аврах тоног төхөөрөмжийн ажиллагаа ба байрлал;
 - 4.7 шалгах нисгэгч нь, шалгалтуудын үр дүнг сургалт дадлагын тайлан бүртгэлд тэмдэглэсэн байх.
- 5/ нисэх багийн ур чадварыг агаарын хөлөг, **эсхүл** энэ зорилгоор зөвшөөрөгдсөн нислэгийн дадлагажуур дээр жилд 2 удаа шалгасан байх.

135.457. Шалгалт өгсөнд тооцох нөхцөл

(а) Багийн гишүүн, онолын болон нислэгийн шалгалтуудыг өгвөл зохих өдрөөс хойш хуанлийн нэг сарын дотор багтааж өгсөн бол түүнийг тогтоосон хугацаандаа шалгалт өгсөнд тооцно.

135.459. Шалгалтын бүртгэл тэмдэглэлийг хадгалах

(а) Гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн гишүүдийн ур чадварын болон онолын шалгалтын бүртгэл тэмдэглэлийг байнга хадгална.

Л БҮЛЭГ. НИСЭХ БАГИЙН ГИШҮҮДИЙН АЖИЛ, АМРАЛТЫН ЦАГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

135.501. Гэрчилгээ эзэмшигчийн үүрэг хариуцлага

(а) Гэрчилгээ эзэмшигч нь иргэний нисэхийн холбогдох дүрэм болон үйл ажиллагааныхаа холбогдох зааврын нөхцөлийг хангаж, нисэх багийн нислэгийн болон амралтын цагийг тодорхойлно.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан тохиолдолд агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэнэ:

- 1/ нисэх багийн гишүүдийн нислэгийн болон ажлын цагийн зохицуулалтыг тусгасан хөтөлбөртэй байх;
- 2/ энэ зүйлийн 1/-д заасан хөтөлбөрт дараах зүйлүүдийг тусгасан байх:
 - 2.1 нислэгийн өмнөх амралтын хугацаа;

- 2.2 цагийн зөрүүд дасан зохицох (acclimatisation);
- 2.3 цагийн бүс;
- 2.4 шөнийн нислэг;
- 2.5 нислэгийн хамгийн их тоо;
- 2.6 нэг нисгэгчтэй нислэг;
- 2.7 хоёр нисгэгчтэй нислэг;
- 2.8 хоёр нисгэгч болон нисэх багийн нэмэлт гишүүд;
- 2.9 нисэх багийн гишүүдийн мэргэшлийн бэлтгэл;
- 2.10 хамтатгасан ажил үүрэг;
- 2.11 нисгэгч, үүрэг гүйцэтгэхийн өмнө буюу дараа зорчигчийн журмаар аялах;
- 2.12 нөөц болон бэлэн үе;
- 2.13 нислэг дэх ажил үүргийн үе;
- 2.14 нислэгийн үед амрах;
- 2.15 нислэгийн үйл ажиллагааны төрөл;
- 2.16 ажлын нийт цаг;
- 2.17 нислэгийн нийт цаг;
- 2.18 ажлын ба нислэгийн цагийг нэмэгдүүлж болох хувилбар (discretionary);
- 2.19 биоритм (circadian rhythm);
- 2.20 амралтын өдрүүд;
- 2.21 бүртгэлийн хадгалалт.

3/ энэ хэсгийн 1/-д заасан хөтөлбөрт дараах шаардлагыг тусгасан байна:

- 3.1 нисэх баг дараалсан 30 хоногийн дотор 160-аас дээш цаг нисэхгүй байх;
- 3.2 нисэх баг нь аливаа 14 хоногийн дотор 2-оос доошгүй өдөр амрах;
- 3.3 нисэх баг нь аливаа 30 хоногийн дотор үргэлжилсэн 4-өөс доошгүй өдөр амрах.

4/ энэхүү хөтөлбөр нь ИНЕГ-аар хүлээн зөвшөөрөгдсөн байна.

(в) Гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн аль нэг гишүүн нислэгийн нөхцөл байдлаас болж нислэгийн явцад ядарч туйлдаж болзошгүйг мэдэж байгаа, эсхүл ингэж үзэх бодит шалтгаан байгаа бөгөөд энэ нь нислэгийн аюулгүй үйл ажиллагаанд нөлөөлнө гэж үзэж байвал тухайн нисэх багийн гишүүнийг нислэгийн үйл ажиллагаанд оролцуулахгүй.

(г) Гэрчилгээ эзэмшигч нь нислэг үйлдэж байгаа нисэх багийн гишүүдийн нислэгийн цагийн үнэн зөв бүртгэлийг, тухайн бүртгэл тэмдэглэл хийгдсэн өдрөөс хойш 6 сарын хугацаанд хадгална.

135.503. Нисэх багийн гишүүний үүрэг хариуцлага

(а) Нисэх багийн гишүүд нь нислэг үйлдэх нөхцөлөөс хамаарч тус тусын үүрэг хариуцлагыг ойлгосон байх ба ядарч болзошгүй гэж үзэж буй тохиолдолд агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцохоос татгалзах үүрэгтэй.

(б) Нисэх багийн гишүүн нь Гэрчилгээ эзэмшигчид гэрээгээр ажиллаж байгаа үедээ нислэгийн өөр үйл ажиллагааг шан хөлсөөр гүйцэтгэх, эсхүл энэ дүрмийн 135.501-ийн (б)-гийн 3/-т заасан нислэгийн болон ажлын цагийн хязгаарлалтыг хэтрүүлэхийг хориглоно.

(в) Аливаа этгээд, энэ дүрмийн 135.501-ийн (б)-ийн 3/-т заасан хязгаарлалтууд хэтрээгүй гэдгийг тодорхойлоогүй тохиолдолд агаарын хөлгийн нисэх багийн гишүүнээр томилогдохыг хориглоно.

(г) Энэ зүйлийн (в)-г үл харгалзан, бусдын амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс үйлдэх нислэгийн үед нисэх багийн аль нэг гишүүний нислэгийн цагийн хязгаарлалт хэтэрснээр нислэгийн аюулгүй ажиллагаа алдагдахгүй байх үүрэг хариуцлагыг агаарын хөлгийн дарга хүлээх ба энэ тохиолдолд нислэгийн цагийн хязгаарлалтыг мөрдөхгүй байж болно.

М БҮЛЭГ. ЗААВАР, НИСЛЭГИЙН ДЭВТЭР БОЛОН БҮРТГЭЛ

135.551. Үйл ажиллагааны мэдээлэл

(а) Гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны заавар нь нисэх багийн гишүүдийн ажил үүрэгт хамааралтай хэсэг нь хүчин төгөлдөр бөгөөд нисэх багийн гишүүд ашиглах боломжтой байна.

135.553. Агаарын хөлгийн бүхээгт авч явах бичиг баримтууд

(а) Нислэг үйлдэх агаарын хөлөг нь нислэг бүрдээ дараах бичиг баримтыг авч явна гэдгийг гэрчилгээ эзэмшигч бататгана:

- 1/ Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний болон Үйл ажиллагааны тодорхойлолтын баталгаажуулсан хуулбар;
- 2/ агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ;
- 3/ нислэгт шаардлагатай NOTAM мэдээ болон нисэхийн мэдээллийн үйлчилгээний баримт бичиг;
- 4/ цаг агаарын мэдээ;
- 5/ аюултай ачааны талаарх мэдээ ;
- 6/ нислэгт холбогдол бүхий нислэгийн зураг, схемийн хувь, хуулбар.
- 7/ хяналтын картууд /QRNC, NC,NNC/;
- 8/ зорчигч тээвэрлэж байгаа тохиолдолд Зорчигчийн нэрсийн жагсаалт /Passenger manifest/;
- 9/ ачаа тээвэрлэж байгаа тохиолдолд Ачааны жагсаалт /Cargo manifest/;
- 10/ түрээсийн агаарын хөлөг ашиглаж байгаа тохиолдолд Чикагогийн конвенцийн 83 bis зүйлийн дагуу гэрээ байгуулсан бол гэрээний баталгаат хуулбар.

135.555. Нислэгийн өдөр тутмын бүртгэл

(а) Гэрчилгээ эзэмшигч нь өдөр тутмын нислэгийн талаар дараах зүйлийг багтаасан бүртгэлийг хөтөлнө:

- 1/ нислэг үйлдсэн сар, өдөр;
- 2/ тээвэрлэгчийн нэр;
- 3/ агаарын хөлгийн даргын нэр;
- 4/ агаарын хөлгийн бүртгэлийн дугаар, тэмдэглэгээ;
- 5/ нислэгийн нийт цаг;
- 6/ зорчигчдын тоо;
- 7/ нислэгийн үйл ажиллагааны төрөл.

135.557. Бүртгэлийг хадгалах

(а) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн холбогдолтой бүртгэл тэмдэглэлүүдийг дараах хугацаагаар хадгална:

- 1/ нислэгийн төлөвлөгөө болон аюултай ачааны талаарх бүртгэл тэмдэглэлийг нислэг үйлдсэн өдрөөс хойш 6 сар хүртэл хугацаагаар;

- 2/ нисэх багийн гишүүдийн нислэгийн болон ажлын цагийн бүртгэлийг бүртгэл хийгдсэн өдрөөс хойш 6 сарын хугацаанд;
- 3/ нисэх багийн гишүүдийн сургалт, дадлага, шалгалтын тайлан, бүртгэлийг тухайн нисэх багийн гишүүн Гэрчилгээ эзэмшигчтэй гэрээгээ цуцалснаас хойш 6 сар хүртэлх хугацаагаар;
- 4/ өдөр тутмын нислэгийн бүртгэлийг нислэг үйлдсэн өдрөөс хойш 6 сараас доошгүй хугацаанд.

(б) ИНД 91-д заасны дагуу бичиг баримтыг агаарын хөлгийн эд ангиудыг ашиглалтаас хассанаас хойш 6 сарын хугацаанд хадгална.

(в) Гэрчилгээ эзэмшигч нь 91-д шаардсан техникийн бүртгэлийг дууссанаас хойш 6 сарын хугацаанд хадгална.

ХАВСРАЛТ А. ХЭРЭГЛЭЛ, ТОНОГЛОЛЫН НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАДВАР БҮХИЙ БҮТЦИЙН СТАНДАРТ

A.1. Бүхээгийн дуу чимээ бичигч /Cockpit voice recorder/

Бүхээгийн дуу чимээ бичигч нь:

- 1/ АНУ-ын Техникийн стандарт ордер (TSO)-ын C84 серийн, эсхүл C123 серийн шаардлагад нийцсэн байна;
- 2/ АНУ-ын TSO-ын C121 серийн шаардлагын дагуу уснаас хамгаалах хэрэгслээр тоноглогдсон байна;
- 3/ Нислэгийн сүүлчийн 30 минутаас багагүй хугацааны үргэлжилсэн бичлэг хийх чадвартай байна.

A.2. Нислэгийн өгөгдөхүүн бичигч / Flight data recorder/

Нислэгийн өгөгдөхүүн бичигч нь:

- 1/ АНУ-ын TSO-ын C124 серийн шаардлагыг хангасан байна;
- 2/ АНУ-ын TSO-ын C121 серийн шаардлагын дагуу уснаас хамгаалах хэрэгслээр тоноглогдсон байна;

- 3/ Нислэгийн 8 цагийн мэдээллийг тоон хэлбэрээр бичиж хадгалах боломжтой байх ба уг мэдээлэл нь арчих боломжгүй байна;
- 4/ MEL-д зааснаас бусад, дор дурдсан тодорхой параметруудийг бичнэ:
- 4.1 зураг 1-д заагдсан;
- 4.2 Хавсралт Б-гийн Хүснэгт 1, эсвэл Хүснэгт 2-т заасан.

Хүснэгт 1. Нислэгийн өгөгдөхүүн бичигчийн параметрт тавигдах шаардлагууд
/Энэхүү хүснэгтэд 135.265-ын шаардлагууд тусгагдсан болно/.

| | (A) | (B) |
|----------|---|---|
| Параметр | 23 Параметр Нисдэг тэрэг | 25 Параметр Нисдэг тэрэг |
| 1 | Хугацаа | Хугацаа |
| 2 | Хурд /хэрэглэлийн/ | Өндөр |
| 3 | Өндөр | Агаарын хурд |
| 4 | Чиглэл | Чиглэл |
| 5 | Босоо хэт ачаалал /Ny/ | Босоо хэт ачаалал /Ny/ |
| 6 | АТС-д радио холбоо дамжуулсан тэмдэглэл | АТС-д радио холбоо дамжуулсан тэмдэглэл |
| 7 | Тангажийн өнцөг | Тангажийн өнцөг |
| 8 | Крений өнцөг | Крений өнцөг |
| 9 | Хэвтээ хэт ачаалал /Nx/ | Хэвтээ хэт ачаалал /Nx/ |

ХАВСРАЛТ Б. ХӨӨРӨХ, БУУХ ЗУРВАС (ХБЗ)

Б.1.1. ХБЗ-ны хамгийн бага өргөн

ХБЗ-ны хамгийн бага өргөнийг тодорхойлохдоо Хүснэгт 1-ийг ашиглан тухайн онгоцны маягт тохирох Аэродромын лавлах код (ARC)-ыг тодруулна. ARC нь онгоцны оврын хэмжээ, нислэгийн үзүүлэлтэд хамааралтай хоёр элементээс бүрдэнэ.

Элемент 1 нь Аэродромын талбайн урт (ARFL)-д үндэслэсэн тоо ба Элемент 2 нь онгоцны размах болон үндсэн гадна дугуйн хоорондын зайд үндэслэсэн үсэг байна.

Б.1.2. Хүснэгт 2-ыг ашиглан ARC-ийг тодорхойлох

- 1/ Онгоцны нислэг үйлдэх аэродромын талбайн урт /ARFL/-ыг тодорхойлно. Тэрхүү талбайн урт нь, зурвасны хазайлт нь "0", тогтуун агаарт, далайн түвшин дэх агаарын стандарт нөхцөлд тухайн онгоцны хамгийн их хөөрөлтийн жинтэй хөөрөлт үйлдэх хамгийн бага талбайн урт юм.
- 2/ Аэродромын талбайн уртаар элемент 1-ийн тоон кодыг тодорхойлно.
- 3/ Онгоцны размах болон үндсэн гадна дугуйн хоорондын зайн хэмжээний хамааралтайгаар элемент 2-ын үсгэн кодыг олно (Жишээ, хэрэв үсгэн код C нь онгоцны размах-д хамааралтай, үсгэн код D нь онгоцны үндсэн гадна дугуйн

хоорондын зайд хамааралтай байхад тухайн онгоцны маягийн хувьд D үсгэн кодыг сонгоно).

Хүснэгт 1. Аэродромын лавлах код (ARC)

| Элемент 1-ийн код | | Элемент 2-ын код | | |
|-------------------|------------------------------|------------------|-----------------------|-----------------------------------|
| Тоон код | Аэродромын талбайн урт(ARFL) | Үсгэн код | Далавчны размах | Үндсэн гадна дугуйн хоорондын зай |
| 1 | 800 м-ээс бага | A | 14,99 м хүртэл | 4,5 м хүртэл |
| 2 | 800м - 1200 м хүртэл | B | 15 м : 23,99 м хүртэл | 4,5 м : 5,99 м хүртэл |
| 3 | 1200м - 1800 м хүртэл | C | 24 м : 35,99 м хүртэл | 6 м : 8,99 м хүртэл |
| 4 | 1800 м-ээс илүү | D | 36 м : 51,99 м хүртэл | 9 м : 13,99 м хүртэл |
| | | E | 52 м : 65 м хүртэл | 9 м : 14 м хүртэл |

Б.1.3. Хүснэгт 2-ыг ашиглан ХБЗ-ны хамгийн бага өргөнийг тодорхойлох.

Онгоцны ARC-ыг тодорхойлсон тохиолдолд, тухайн ХБЗ-ны өргөнийг зохих тоон код, үсгэн код хоёрын огтлолцлоор тодорхойлно. Жишээ нь, хэрэв онгоцны ARC нь 2C бол шаардлагатай зурвасны өргөн нь 30м байна.

Хүснэгт 2. ХБЗ-ны өргөн

| Тоон код | Үсгэн код | | | | |
|----------|-----------|-----|-----|-----|-----|
| | A | B | C | D | E |
| 1 | 18м | 18м | 23м | - | - |
| 2 | 23м | 23м | 30м | - | - |
| 3 | 30м | 30м | 30м | 45м | - |
| 4 | - | - | 45м | 45м | 45м |

Б.1.4. Нислэгийн талбайн хамгийн бага өргөн

Онгоцны маяг тус бүрийн хувьд нислэгийн талбайн хамгийн бага өргөнийг Хүснэгт 3-ын дагуу тодорхойлно.

Хүснэгт 3. Нислэгийн талбайн өргөн

| Тоон код | ХБЗ-ны төрөл | Талбайн өргөн |
|-----------|---|---------------|
| 3 эсхүл 4 | Нарийн хэмжилттэй /Precision/ хэрэглэлээр ойртолт үйлдэх олон улсын нисэх буудал дахь ХБЗ | 300м |
| 3 эсхүл 4 | Нарийн хэмжилттэй /Precision/ хэрэглэлээр ойртолт үйлдэх ХБЗ | 220м |
| 1 эсхүл 2 | нарийн хэмжилттэй /Precision/ хэрэглэлээр ойртолт үйлдэх ХБЗ | 150м |

| | | |
|--------|--|------|
| 3 ба 4 | Нарийн хэмжилтгүй /Non-Precision/ хэрэглэлээр ойртолт үйлдэх эсхүл хэрэглэлийн бус ойртолттой ХБЗ | 150м |
| 3 ба 4 | Зөвхөн өдрийн цагаар хэрэглэлийн бус ойртолттой, 22700 кг-аас ихгүй хөөрөлтийн хүндтэй онгоцонд зориулагдсан | 90м |
| 1 ба 2 | Нарийн хэмжилтгүй /Non-Precision/ хэрэглэлээр ойртолт үйлдэх ХБЗ | 150м |
| 2 | Хэрэглэлийн бус ойртолт үйлдэх ХБЗ | 80м |
| 1 | Хэрэглэлийн бус ойртолт үйлдэх ХБЗ | 60м |

---oOo---